Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... сарын ..... өдөр Төрийн ордон, Улаанбаатар хот

## КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

2 дугаар зүйл. Монгол Улс соёлын эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэл, буцаах хүсэлтийг "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн конвенцын 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (а) болон (с)-д заасны дагуу гаргаж болохыг мэдэгдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

# ТАВ. ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Уг бүлэгт "Хулгайлагдсан эсвэл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн Конвенц"-ыг соёлын биет өвийг хамгаалах, соёлын эд зүйлийн хууль бус худалдаатай тэмцэхэд чиглэсэн олон улсын олон талт гэрээнүүдтэй харьцуулна.

Монгол улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт[70] зааснаар Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх тул Монгол Улс нэгдэн орсон "Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай Конвенц", "Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах Конвенц", "Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай Конвенц"-ийн хүрээнд авч үзье.

## 5.1."Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай Конвенц"[71]

Хэлэлцэн тохирогч талууд нь зэвсэгт мөргөлдөөн, дайны улмаас аливаа ард түмний соёлын үнэт зүйлс ноцтойгоор гэмтэж, устах зэргээр соёлын үнэт зүйлст хохирол учрах нь хүн төрөлхтөний соёлын үнэт зүйлст хохиролтой тул соёлын өвийг хамгаалах нь дэлхийн бүх ард түмний хувьд чухал ач холбогдолтой бөгөөд эдгээр өвийг олон улсын хамгаалалтад авах нь чухал гэж үзэж 1956 оны 8 дугаар сарын 7-ны өдөр энэхүү эрх зүйн баримт бичгийг батлан гаргажээ. 7 бүлэг 40 зүйл бүхий энэхүү Конвецийг хэрэгжүүлэх 4 бүлэг 21 зүйл бүхий тусгайлсан журамтай. Конвецид Монгол Улс 1964 оны 11 дүгээр сарынн 4-нд нэгдэн оржээ.

Үндсэндээ зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлс гэмтэх, устаж үгүй болохоос урьдчилан сэргийлэх, хамгаалахад конвенц чиглэгдсэн боловч тайван цагт соёлын үнэт зүйлсийг хамгаалах үндэсний болон олон улсын арга хэмжээ авахгүйгээр тийм хамгаалалт ямар ч үр дүнгүй болохыг анхааруулсан байдаг. Конвенцын зорилгоос хамаарч "Соёлын үнэт зүйлс" гэсэн тодорхойлолтод соёлын хөдлөх болон үл хөдлөх дурсгалт зүйлс, хөдлөх үнэт зүйлсийг хадгалах зориулалт бүхий музей, номын сан, архивын байр, /хоргодох байр/, цогцолбор төвүүдийг багтаасан.

Энэхүү конвенц нь "онцгой нөхцөл"-д хэрэгжих тул ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенцтой шууд хамааралгүй. Конвенцын 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт: Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд соёлын үнэт зүйлсийн эсрэг шууд чиглэсэн аливаа үйлдэл, *хулгай, дээрэм буюу хууль бусаар эзэмших бусад хэлбэрийг* хэрэв шаардлагатай бол зогсоох, урьдчилан сэргийлэх, хориглох үүрэг хүлээхээр заасныг онцолж болох юм. Дайн, зэвсэгт мөргөлдөөн, нийтийн эмх замбараагүй байдал, гамшигийн үеийг далимдуулан соёлын эд зүйлийг хулгайлах, завших гэмт хэрэг үйлдэгдэх магадлал өндөр бөгөөд түүнийг шалгаж тогтооход ихээхэн хүндрэлтэй. Улмаар зэвсэгт мөргөлдөөний үед хулгайлагдсан эсвэл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг буцаах асуудал яригдана. Гэхдээ үүнийг уг Конвенцын I Протоколд заасан: оролцогч улсууд зэвсэгт мөргөлдөөний үед эзэлсэн улсынхаа нутаг дэвсгэрээс хууль бусаар соёлын үнэт зүйлс экспортлохыг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатайгаас гадна импортолсон соёлын өвийг хураан авч, зэвсэгт мөргөлдөөн дуусахад буцаан өгөх, сайн санаат эзэмшигчид урьд

---

[70] Монгол улсын Үндсэн хууль. УБ, 1992 он. Төрийн мэдээлэл №1 /7/ 3 дахь тал.

[71] Төрийн мэдээлэл. Тусгай дугаар IV боть. УБ хот. 2006 он. 1325 дахь тал

эзэлсэн улс нөхөн төлбөр олгох зэрэг хэлэлцэгч улсуудын хүлээсэн үүргийн хүрээнд шийдвэрлэх боломжтой.

Нэмж дурдахад 1999 онд батлаж, 2004 онд хүчин төгөлдөр болсон Конвенцын II Протоколд эзэлсэн тал, эзлэгдсэн улсын нутаг дэвсгэр дээр соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, зөөж нүүлгэх, эсвэл өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох; археологийн малтлага хийхийг хориглох; түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдолтой мэдээллийг устгах, нуун дарагдуулах зорилгоор соёлын үнэт зүйлийг өөрчлөхийг хориглох; санаатайгаар үйлдсэн соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, нүүлгэн зөөсөн эсвэл өмчлөх эрхийг шилжүүлсэн аливаа үйлдэлд хуулийн, захиргааны, эсвэл сахилгын арга хэмжээг оролцогч улсууд авах талаар тусгасан байдаг. Эдгээр нэмэлт протоколуудад манай улс хараахан нэгдээгүй байна.

### 5.2. "Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах Конвенц"[72]

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий бага хурал 1972 оны 10 дугаар сарын 17-ноос 11 дүгээр сарын 21-нд Парис хотноо чуулсан 17 дугаар чуулганаараа хамгаалвал зохих баялаг бүхий улс орны эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн нөөц бололцоо хүрэлцээгүйн улмаас уг өвийг үндэсний хэмжээнд хамгаалах арга зам ихэнхдээ хангалтгүй байдаг тул байгалийн болон соёлын өвийг нийтээр хамгаалах үр ашигтай систем тогтоох талаар хэлэлцэн тохиролцсон шинэ дүрэм боловсруулах нь зайлшгүй чухал хэмээн үзэж энэ асуудлаар олон улсын конвенц байгуулахаар 16 дугаар чуулганаар шийдвэрлэсэн учир 1972 оны 11 дүгээр сарын 16-нд энэхүү Конвенцийг баталжээ. Монгол улс 1990 оны 2 дугаар сарын 2-нд нэгдэн орсон байна.

Хууль бус худалдаатай шууд хамааралгүй боловч дэлхийн соёлын болон байгалийн өвийг илрүүлэх, хамгаалах, хадгалах, сурталчлах төдийгүй хойч үедээ өвлүүлэн өгөх, олон улсын хамгаалалтанд авах, тусламж үзүүлэх талаарх соёлын /Дэлхийн өвийн хороо, Дэлхийн өвийн сангийн/ үйл ажиллагааг тусгасан энэхүү олон улсын гэрээ нь ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенцтой соёлын өвийг /Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх, дэлхийн соёлын өвийн жагсаалтад бүртгэгдсэн  хөшөө дурсгал, археологийн цогцолбор, дурсгалт газар г.м/ хадгалж, хамгаалах  нийтлэг зарчмаар холбогдоно.

### 5.3. "Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай Конвенц"[73]

Олон улсын хэмжээнд соёлын үнэт зүйлийн хууль бус худалдаатай тэмцэх үндсэн гол баримт бичиг юм. НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий бага хурал Парис хотноо 1970 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдрүүдэд болсон арван зургаадугаар чуулганаараа шинжлэх ухаан, соёл, боловсролын зорилгод үндэстэн хоорондын соёлын үнэт зүйлсийн солилцоо нь хүн төрөлхтөний иргэншлийн тухай мэдлэгийг нэмэгдүүлэх, бүх ард түмний соёлын амьдралын баяжуулах, үндэстэн хоорондын харилцан хүндэтгэл, талархлыг төлөвшүүлэх чухал ач холбогдолтой болохыг дурьдаад улс бүр өөрийн нутаг дэвсгэрт буй соёлын үнэт зүйлсийг хулгай, нууцаар ухаж авах болон хууль бус экспортын аюулаас хамгаалах үүрэгтэй  бөгөөд эдгээр аюулыг

---

[72] Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Улсын мэргэжлийн хяналтын газар. Түүх соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад. УБ, 2008 он. 328-339 дэх тал.

[73] Төрийн мэдээлэл. Тусгай дугаар IV боть. УБ хот. 2006 он. 996 дахь тал

таслан зогсооход улс бүр өөрийн болон бүх үндэстний соёлын өвийг хүндэтгэх ёс суртахууны үүргийг ухамсарлах шаардлагатайн дээр хоёр болон олон улсын хооронд нягт хамтын ажиллагааг бий болгосон тохиолдолд үр дүнтэй хэмээн үзэж 1970 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр энэхүү конвенцийг батласан бөгөөд Монгол улс 1990 оны 5 дугаар сарын 23-ны өдөр нэгдэн оржээ.

1970 оны Конвенцид нэмэлт дэмжлэг болох олон улсын баримт бичиг боловсруулахыг ЮНЕСКО-гийн зүгээс ЮНИДРУА-д хүсэлт гаргаснаар 1995 онд Хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн Конвенц хүчин төгөлдөр болсон.[74] Иймээс энэ хоёр конвенц маш нарийн уялдаатай. Ерөнхийдөө 1970 оны Конвенцид анх тусгагдсан зарчмуудыг олон улсын хувийн эрх зүйн болон шүүхийн процессод бодитоор хэрэгжүүлэх боломжийг 1995 оны Конвенц баталгаажуулсан гэж мэргэжилтнүүд үздэг.

**Конвенцуудын ижил болон ялгаатай тал, зохицуулалтын харьцуулалт:**

1. Эдгээр 2 конвенц нь дэлхий нийтийн хүндрэлтэй асуудал болоод байгаа соёлын үнэт зүйлсийн хууль бус худалдааны эсрэг тэмцдэг.
2. Эсрэг үйлчлэл үзүүлдэггүй бөгөөд зөвхөн хууль бус гарал үүсэлтэй соёлын үнэт зүйлст хамаатай /хулгай болон хууль бус экспорт/
3. 1970 оны Конвенцын 1 дүгээр зүйлд заасан "соёлын үнэт зүйл"-ийн тодорхойлолтын тусгайлан заасан /specifically designated/ гэдгийг хасаад бусад нэр томьёо, үг хэллэг, ангилалыг 1995 оны Конвенцын 2 дугаар зүйлд заасан "соёлын эд зүйл"-ийн тодорхойлолт болон хавсралтад шууд оруулсан. Ингэснээр 1995 оны Конвенцын дагуу нэхэмжлэлийг нийтийн болон хувийн өмчийн төдийгүй бүртгэгдээгүй, танигдаж амжаагүй соёлын эд зүйлд хэрэглэх боломж нээгджээ.
4. 1970 оны Конвенцын 3 дугаар зүйлд: Оролцогч улсуудаас баталсан журмыг зөрчин соёлын үнэт зүйлсийг импортлох, эскпортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хууль бус гэж үзнэ; 11 дүгээр зүйлд: Аливаа улсыг гадаад улс эзлэн түрэмгийлсний шууд буюу шууд бус уршгаар соёлын үнэт зүйлсийг хууль бусаар экспортолж, түүнийг өмчлөх эрхийг хүчээр шилжүүлсэн бол тэдгээр үйлдлийг мөн хууль бус гэж үзнэ; 1995 оны Конвенцын 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: Хууль бус малтлагын үр дүнд олдсон, эсвэл хууль ёсны дагуу малтлагын үр дүнд олдсон боловч хууль бусаар авч үлдсэн соёлын эд зүйлийг тухайн малтлага хийгдсэн улсын хуульд нийцэж буй бол энэхүү конвенцын зорилгоор хулгайлагдсан гэж үзнэ; 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: Соёлын эд зүйлийн экспортыг зохицуулах хуулийн дагуу зөвшөөрөлтэйгөөр хүсэлт гаргаж буй улсын нутаг дэвсгэрээс үзэсгэлэн, шинжилгээ судлагаа болон сэргээн засварлах зорилгоор түр хугацаанд экспортлогдсон соёлын эд зүйл нь хугацаандаа эх орондоо буцаан ирээгүй тохиолдолд түүнийг хууль бусаар экспортолсон гэж үзнэ гэж тус тус нарийвчлан тодорхойлжээ.
5. 1970 оны Конвенцын 6 дугаар зүйлийн (а)-д экспортын зөвшөөрөл олгох гэрчилгээ бий болгож, б)-д гэрчилгээгүй соёлын үнэт зүйлсийг экспортлохыг хориглохыг үүрэг болгосон бол 1995 оны Конвенцын 6 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлийг эзэмшигч мэдээгүй, мэдэх боломжгүй байсныг тодорхойлохдоо экспортын гэрчилгээ байсан эсэхийг харгалзахаар заасан нь харилцан уялдаа бүхий зохицуулалт байна.
6. 1970 оны Конвенцын дагуу тухайн улсын хуульд нийцвэл шүүхэд нэхэмжлэл гаргаж болох ч хүсэлтийг голчлон дипломат шугамаар дамжуулж 7 (б)(iii) тухайн улс гаргадаг.

[74] "ЮНЕСКО-Монакогийн хамтын ажиллагаа" Соёлын эд зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх чадавх дээшлүүлэх төсөл. Үр дүнгийн Тайлан 2009-2011 (I үе шат). УБ хот 2013 он. 34 дэх тал.

Оролцогч улсын хуулиар зөвшөөрвөл хувь хүн, эсвэл хуулийн этгээд гаргаж болно. 13 (c) Харин 1995 оны Конвенцид нэхэмжлэлийг тухайн соёлын эд зүйл байгаа оролцогч улсын шүүх, эрх бүхийн байгууллагад гаргаж 8(1) болохоос гадна талууд маргаанаа бусад шүүх эсвэл арбитрад хүргүүлэхээ 8(1) тохирч болно. Соёлын эд зүйлийг хулгайлсан тохиолдолд эгүүлэн олгох нэхэмжлэлийг улс, эсвэл хуулийн этгээд, хувь хүн; хууль бусаар экспортолсон тохиолдолд буцаах хүсэлтийг зөвхөн улс нь гаргана. 1995 оны Конвенц нь олон улсын хувийн эрх зүй давамгайлсан заалтуудтай байна.

7. 1970 оны Конвенцын 7 дугаар зүйлийн б)-гийн (i)-д: Бусад оролцогч улсын музей, шашны болон соёлын байгууллагаас алдагдсан бүртгэлтэй соёлын эд зүйлийг нөгөө оролцогч улс импортлохыг хориглосон ба 1995 оны Конвенцын 3 дугаар зүйлийн (4) дэх хэсэгт ийм соёлын эд зүйлийг эргүүлэн олгох нэхэмжлэлд үнэмлэхүй хязгаарлах хугацаа үйлчлэхгүй байхаар тусгажээ. Үүнийг аль аль нь бүртгэл тооллогод хамрагдсан соёлын эд зүйлд "давуу эрх" олгосон явдал гэж болох юм.

8. Мөн 7 дугаар зүйлийн б)-гийн (ii)-д: Хууль бусаар импортлогдсон соёлын эд зүйлийг илрүүлэх, буцаан өгөхөд хүсэлт гаргагч улс нь шударга эзэмшигчид нөхөн төлбөр төлнө гэж ерөнхий заасан бол 1995 оны Конвенцын 4 болон 6 дугаар зүйлд нөхөн олговор авах шалгуур, гуравдагч этгээдээр төлүүлэх эрх, эзэмшигчийн нөхөн олговрын оронд гаргах шийдвэр зэргийг дэлгэрэнгүй зааж өгчээ.

9. 1970 оны Конвенцын 9 дүгээр зүйлд: Археологийн болон угсаатны зүйн материалыг хулгайлснаас үүдэх соёлын сан хөмрөг нь аюулд учирсан оролцогч аливаа улс холбогдох бусад улсад хандаж болно гэсэн зарчмын шинжтэй заалт оруулсан бол 1995 оны Конвенцын удиртгал хэсэг болон 2, 3 дугаар бүлгийн холбогдох зүйлүүдэд хулгайлагдсан археологийн дурсгал, овог, уугуул иргэд, үндэстний уламжлалт зан заншилтай холбоотой соёлын эд зүйлд онцгой анхаарал хандуулжээ.

10. Эцэст нь 1970 оны Конвенцид соёлын үнэт зүйлсийг хууль бусаар экспортлох, импортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар оролцогч улсад үүрэг болгосон заалтууд /5, 6, 7, 8, 10, 12, 13 дугаар зүйлүүд/ дийлэнх хувийг эзэлж байгаа бол 1995 оны Конвенцид хулгайлагдсан эсвэл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг эргүүлэн авах, буцаахтай холбоотой нэхэмжлэгч этгээд, хүсэлт гаргагч улс болон шударга эзэмшигчид эрх олгосон, боломж өгсөн заалтууд /3(4), 3(8), 4 (1-4), 5(1), 5(3), 6(1), 6(3), 6(4), 7(2), 8, 9(1),10(3) голлож байна.

## ЗУРГАА. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" зэрэг бодлогын баримт бичгүүдэд түүх, соёлын үнэт зүйлс хууль бусаар гадаадад гарахаас сэргийлэх, хилийн чанад дахь соёлын өвийг сурвалжлан олох, судлах, бүртгэх, эх орондоо эгүүлэн залах, энэ чиглэлээр гадаад орontой идэвхтэй хамтран ажиллах эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авах, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх эрх зүйн орчныг сайжруулах, соёлын өвийг хамгаалах тогтвортой механизм бүрдүүлэх зорилтуудыг дэвшүүлжээ.

2. Манай улсад одоогоор соёлын биет өвийг хайх, судлах, бүртгэх, тээвэрлэх, сурталчилах, шинжлэх, хувилах, ашиглах, худалдан авах, борлуулах, шилжүүлэх, бэлэглэх, хадгалах, тооллого хийх, авран хамгаалах, хилээр нэвтрүүлэх, эрэн сурвалжлах, эргүүлэн авчрах зэрэг үйл ажиллагааг зохицуулсан 3 олон улсын гэрээ, .... хууль, ... дүрэм, журам, жагсаалт хүчин төгөлдөр үйлчилж байгаа боловч хууль бусаар хилийн чанадад гарсан соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаах үйл ажиллагааг олон улсын түвшинд зохицуулсан эрх зүйн баримт бичиг дутагдалтай байна. 1991 онд нэгдэн орсон "Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай Конвенц" хэт ерөнхий тул шууд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй. Энэ асуудлыг шийдэх зорилгоор олон улсын хувийн эрх зүйн нарийвчилсан зохицуулалт бүхий "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" конвенцыг ЮНИДРУА 1995 онд баталсан байна.

3. Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай бүс нутгийн сургалт, семинар /2003 он/, соёлын үнэт зүйлийн хууль бус худалдаатай тэмцэх чадавхийг дээшлүүлэх улсын хэмжээний сургалт хэлэлцүүлэгт /2011 он/ оролцогчдоос Монгол Улсыг "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн конвенцид богино хугацаанд цаг алдалгүй нэгдэн орохыг зөвлөжээ. Мөн НҮБ-аас 2014 онд баталсан соёлын үнэт зүйлийн худалдаа болон бусад холбогдох гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх олон улсын удирдамжид гишүүн орнуудыг 1970 оны ЮНЕСКО-гийн болон 1995 оны ЮНИДРУА-гийн конвенц, бусад холбогдох олон улсын олон талт гэрээг соёрхон баталж, хэрэгжүүлэх шаардлагатайг дурджээ.

4. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд 2021 оны 5 дугаар сарын байдлаар 9754 дурсгалт газрын 90043 ширхэг түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүртгэгдсэн бол хамгийн сүүлд буюу 2018 оны 11 сараас 2019 оны 3 дугаар сар хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулсан улсын тооллогоор 126810 дэсийн 276077 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдож, 99 байгууллагын 435 дэсийн 875 ширхэг хөдлөх дурсгалт зүйл дутсан байна. Тоолж бүртгэсэн болон хараахан малтаж, судалж амжаагүй, бүртгэгдээгүй түүх, соёл, шинжлэх ухааны чухал ач холбогдол бүхий соёл иргэншлийн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох соёлын өвийг бүртгэн хамгаалах, хууль бусаар алдагдахаас урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлага тулгарна.

5. Цагдаагийн байгууллагад 2000-2015 он хүртэлх хугацаанд түүх, соёлын дурсгалт зүйлийг хулгайлах, дээрэмдэх, залилан мэхэлж авах, завших, үрэгдүүлэх нийт 84 гэмт хэрэг, эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсноос хойшхи хугацаанд бурхан, шашны эд өлгийн зүйл хулгайлах, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын

хилээр хууль бусаар нэвтрүүлэх, түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах, хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийх, соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх нийт 76 бүртгэгдэн шалгагджээ. Сүүлийн 5 жилийн хугацаанд зөвхөн хулгайлах гэмт хэргийн улмаас алга болсон нийт 52 түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн сурвалжилж, 22 эд зүйлийг олсон бол 17 эд зүйлийн эрэн сурвалжлалтыг зогсоож, 13 эд зүйлийг эрж хайсаар байна.

6. "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн конвенц нь удиртгал, V бүлэг 21 зүйл (I. Хэрэглэх хүрээ ба тодорхойлолт /1-2 зүйл/, II. Хулгайлагдсан соёлын эд зүйлийг эгүүлэн олгох /3-4 зүйл/, III. Хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг буцаах /5–7 зүйл/, IV.Ерөнхий заалт /8–10 зүйл/, V.Төгсгөлийн заалт /11–21 зүйл/)-ээс бүрдэх бөгөөд хүн төрөлхтний соёлын солилцоо болон соёлын өвийг хамгаалахын ач холбогдол хийгээд үндэстэн, ард түмний соёлын өв, археологийн дурсгалт газрууд ухаж тоногдохоос урьдчилан сэргийлэх явдлыг ухамсарлаж, хэлэлцэн тохиролцогч улсуудын хооронд соёлын эд зүйлийг эгүүлэн олгох болон буцаах нийтлэг зохицуулалтыг бий болгож, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар соёлын эд зүйлийн хууль бус худалдаатай үр дүнтэй тэмцэхэд дэмжлэг үзүүлэх зорилгыг агуулжээ.

7. Конвенцид Латин америк, Африк, скандинав, зүүн болон өмнөд Европ, Ойрхи дорнод, зүүн Азийн нийт 53 улс нэгдэн орсон байна. Эдгээр улсуудын дийлэнх хэсэг нь нийгэм, эдийн засгийн хувьд хөгжиж буй орнууд бөгөөд соёлын өв нь эрсдэлд орж болзошгүй Афганистан, Болив, Гондурас, Койтэ д'войр, Мадагаскар, Нигер, Румын, Перу, Сири зэрэг улсууд багтжээ. АНУ, Их Британи, Австри, ХБНГУ, Япон гэх мэт соёлын үнэт зүйлийн томоохон зах зээлтэй, импортлогч орнуудын хувьд конвенцыг бүхэлд нь эсхүл бүлэг, заалтуудыг аль нэг талаар шүүмжилж нэгдэн орохоос татгалзжээ. Харин 2 хөршийн хувьд: ОХУ 1996 оны 06 сарын 29-нд гарын үсэг зурсан боловч одоог хүртэл соёрхон батлаагүй бол БНХАУ 1997 оны 05 сарын 07-нд нэгдэн орсон байна.

8. Тус конвенц нь дотоодын хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах замаар хэрэгжүүлдэг бусад гэрээнүүдтэй харьцуулахад эрх зүйн үндэслэл болж чадах шууд хэрэглэх бололцоо бүхий заалтуудтай бөгөөд Монгол Улсын хуульд зааснаас өөр /илүү нарийн/ журам тогтоож байгаа тул Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсэгт заасны дагуу заавал соёрхон баталж хууль гаргана. Иймд "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцид нэгдэн орох зорилгын зохицуулалтын хувилбар нь конвенцыг соёрхон батлах хуулийн төсөл боловсруулж батлах юм. Соёрхон батлах тухай хуулийн төслийг хуульд заасан журмын дагуу хэлэлцэж, гэрээг Монгол Улсын Их Хурал соёрхон баталж хууль гаргасан тухай батламж жуух, холбогдох баримт бичгийг гэрээний эх хадгалагч буюу Итали улсын Засгийн газарт хүргүүлснээс 6 сарын дараа конвенц хүчин төгөлдөр болно.

9. Конвенцыг соёрхон батлах буюу нэгдэн ороход улсын төсвөөс олон улсын гэрээ байгуулах асуудлаар хэлэлцээ хийх, томилолтоор ажиллах, төлөөлөгчид хүлээн авах, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах, олон улсын гэрээ байгуулах, олон улсын гэрээнд нэгдэн ороxтой холбоотой судалгаа хийх, олон улсын гэрээг орчуулах, орчуулгыг хянан баталгаажуулах, олон улсын гэрээний тусгай хэвлэмэл хуудас, хавтас, үдээс, лац захиалах урсгал зардал гарах бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд захиргааны ачаалал, нэмэлт зардал үүсгэхгүй. Мөн гэрээний хэрэгжилтийг тайлагнах шаардлагагүй ба

цаашид конвенцыг ашиглан соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаан авах нийгмийн үр өгөөж гарах зардлаас ямагт өндөр тусна.

10. Соёлын биет өвийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, хууль бусаар алдагдсан хилийн чанад дахь соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаан авах үр ашигтай олон улсын эрх зүйн орчныг бий болгож буй явдал нь конвенцид нэгдэн орохын эерэг тал юм. Харин хэлэлцэн тохиролцогч улсаас манай улсад хууль бусаар оруулж ирсэн соёлын эд зүйлийг конвенцын дагуу эгүүлэх, буцаан өгөх шаардлага үүснэ. Гэвч үүнийг сөрөг тал гэж дүгнэхэд зохисгүй. Учир нь хэлэлцэн тохиролцогч аль нэг улсаас нэхэмжлэл, хүсэлт гаргасан тохиолдолд тухайн хууль бус соёлын эд зүйлийг эгүүлж, эсхүл буцааснаар бид олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлсэн хэрэг болно. Түүнчлэн түүх соёл, зах зээл, газар зүйн байршил, хуулийн хориглолт зэргээс шалтгаалан манай улс соёлын үнэт зүйлийн  импортлогч орон биш бөгөөд Монгол Улсад хууль бусаар оруулж ирсэн соёлын үнэт зүйлийн талаарх мэдээлэл, судалгаа алга байна.

11. Конвенцыг соёрхон батлснаар хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд ялгаварлан гадуурхах, хүний эрхийг зөрчих, боломжийг хаах ямар нэг сөрөг нөлөөгүй бөгөөд соёлын эд зүйлийн хууль ёсны өмчлөгч, шударга эзэмшигч, хохирогчийн эрхийг хамгаалах, иргэн, хуулийн этгээдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулах, соёлын өвийг хамгаалах чиглэлд Засгийн газар, холбогдох яам, агентлаг, байгууллага, албан тушаалтны үүрэг, үйл ажиллагаа, гадаад харилцааг дэмжих, иргэдийн итгэл үнэмшил, идэвх оролцоог нэмэгдүүлэх, энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулах, хосолмол өв бүхий газар нутаг, газрын хэвлий дэх олдворыг хамгаалах, соёлын үнэт зүйлийн хууль бус худалдааны сөрөг нөлөөллийг бууруулах, гадаад улсад хууль бусаар гаргасан соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаах боломж нөхцлийг бүрдүүлэх зэрэг сайн үр нөлөө үзүүлэхээр байна. Гэхдээ хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг мэдсээр байж шилжүүлэн авсан этгээд тодорхой хязгаарлалтад өртөх ба нэхэмжлэл, хүсэлт гаргагч, хүлээн авагч улсууд соёлын өвийн бүртгэл мэдээлэл, судалгааг улам сайжруулах шаардлага гарна.

12. Конвенцын зохицуулалтын дагуу соёлын эд зүйлийг эгүүлэн олгох, буцаах асуудалд хэлэлцэн тохиролцогч улс, түүний төрийн болон орон нутгийн, шашны, олон нийтийн байгууллага, хуулийн этгээд, соёлын биет өвийн хууль ёсны өмчлөгч хувь хүн, бүтээгч, нутгийн уугуул иргэд, үндэстэн, ястан, угсаатан болон эртний эдлэлийн худалдаа эрхлэгч, сонирхон цуглуулагч, соёлын эд зүйлийн шударга эзэмшигч, соёлын эд зүйлийг хулгайлсан, хууль бусаар экспортлосон, хууль бус болохыг мэдсээр байж худалдан авсан, бусдад шилжүүлсэн этгээд болон шударга эзэмшигчид нөхөн олговорыг сайн дураараа төлөх гуравдагч этгээдийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна.

13. Конвенцын үзэл санаа, зорилго, зарчим нь манай улсын соёлын иргэншлийн аюулгүй байдлыг хангах, соёлын өвийг хамгаалах бодлого, үйл ажиллагаатай нийцэх бөгөөд конвенцын зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад холбогдох хууль тогтоомжтой харшлах зүйлгүй байна. Хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйл хэлэлцэн тохиролцогч нөгөө улсад байгаа тохиолдолд эгүүлэн олгох, буцаах олон улсын шинжтэй нэхэмжлэлд конвенцыг хэрэглэнэ. Конвенцын "соёлын эд зүйлс" гэх тодорхойлолтод ЮНЕСКО-гийн 1970 оны Конвенцын соёлын үнэт зүйлийн ангилалд хамаарах зүйлсийг шууд оруулсан ба Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, эрх зүйн актуудад тусгагдсан түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамаарах эд зүйлстэй харьцуулахад агуулгаараа яг таарч байна. Конвенцид бичээс, зоос,

сийлбэр, тавилга, хуучны хөгжмийн зэмсэгийн зүйлсийг 100-гаас илүү жилийн насжилттай байхыг онцолсон нь манай хуультай зөрчилдөх зүйлгүй.

14. Хулгайлагдсан соёлын эд зүйлийг эгүүлэн олгох, хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг буцаах үндэслэл, нөхцөл, шаардлагыг журамласан конвенцын II, III бүлгийн зүйл заалтууд Монгол Улсын Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, ААҮАТЗТХ, Гаалийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Музейн тухай хууль, Номын сангийн тухай хууль, Иргэний хууль, ИХШХШТХ, Соёлын тухай хууль, СӨХТХ, Олон улсын гэрээний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Шүүхийн тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Эрүүгийн хууль, ЭХХШТХ болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад холбогдох жагсаалт, дүрэм, журамтай зохицож байна.

15. Улсын хилээр нэвтрүүлэх гэдэгт эд зүйлийг хилээр гаргах, оруулах, дамжин өнгөрүүлэх үйлдлүүд багтдаг. Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт"-ын XXI хэсгийн түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх ялгааг зөвхөн "гаргах" гэсэн нь хууль бусаар гадагш гарсан соёлын эд зүйлийг конвенцын дагуу оруулахад хүндрэл үүсгэхээр байна. Иймд түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх ялгааг "гаргах, оруулах" болгож өөрчлөхийн зэрэгцээ хэрэглэхээ больсон хүчингүй (эртний үнэт, ховор зүйлс, түүх, соёлын өрдийн дурсгалт зүйл, БСШУЯ г.м) нэр томьёо, үг хэллэг агуулсан журмыг уг хэсгийг яаралтай шинэчлэн найруулах шаардлагатай.

16. Конвенцын IV бүлэгт хулгайлагдсан соёлын эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэл, хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг буцаах хүсэлт гаргах, хүлээн авах, шийдвэрлэх байгууллага, түр хамгаалалт, конвецыг хэрэглэх нөхцөл, бусад эрх зүйн зохицуулалтыг үл хязгаарлах талаар, V бүлэг буюу төгсгөлийн заалтад конвенцид гарын үсэг зурах, хүлээн зөвшөөрөх, соёрхон батлах, нэгдэн орох, батлах, мэдэгдэл гаргах, тайлбар хийх, цуцлах, хүчин төгөлдөр болох үндэлслэл, журам болон ЮНИДРУА, гэрээний эх хадгалагч (Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар)-ийн эрх, үүргийг заажээ. Дээрх зохицуулалт нь Олон улсыг гэрээний тухай Венийн Конвенц, Дипломат харилцааны тухай Венийн Конвенц, Консулын харилцааны тухай Венийн Конвенц, Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуулийн хэм хэмжээтэй харилцан уялдаж байна.

17. Конвенцид нэгдэн ороходоо хулгайлсан эд зүйлийг эгүүлэх нэхэмжлэлийн хязгаарлах хугацааг 75 жил, түүнээс урт хугацаагаар тогтоох тухай 3(5), конвенцыг заалтыг хэрэглэхгүй байх тухай 13(3), үйлчлэх нутаг дэвсгэрийг тогтоох тухай 14(1), соёлын эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэл, буцаах хүсэлт гаргах журмын тухай 16(1), шүүх болон эрх бүхий байгууллагыг томилох тухай 16(2) мэдэгдэл хийнэ. Үүнээс 16(1)-т зааснаас бусад мэдэгдлийг сайн дурын үндсэн дээр хийх бөгөөд тандан судалгаагаар эдгээр мэдэгдлийг хийх шаардлагагүй гэж үзсэн болно. Соёлын эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэл, буцаах хүсэлт гаргах журмын тухай заавал мэдэгдэх 16(1) заалтын тухайд ийм нэхэмжлэл, хүсэлтийг хүлээн авч шүүхэд дамжуулах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагыг одоогоор манай улс томилоогүй тул (а) болон (с) хувилбарын дагуу шууд тухайн улсын шүүх болон эрх бүхий байгууллагад, эсвэл дипломат болон консулын шугамаар гаргах талаар мэдэгдэл хийх нь оновчтой юм.

18. Конвенцыг 17 дугаар зүйлд заасны дагуу соёрхон баталж хууль гаргасан тухай батламж жуух бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш 6 сарын дотор Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон Монгол Улсын хилээр тарифын бус бусад хязгаарлалттай нэвтрүүлэх бүлэг барааны жагсаалт, Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалтын холбогдох хэсгийг, Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам, Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам зэргийг бүхэлд нь англи, франц аль нэг хэлээр орчуулж, гэрээний эх хадгалагчид хүргүүлэх шаардлага үүснэ.

19. Монгол Улс 1964 онд нэгдэн орсон "Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай Конвенц" нь онцгой нөхцөлд хэрэгжих тул ЮНИДРУА-гийн конвенцтой шууд хамааралгүй. Гэвч хэлэлцэн тохиролцогч улсууд зэвсэгт мөргөлдөөний үед эзэлсэн улсынхаа нутаг дэвсгэрээс хууль бусаар соёлын үнэт зүйлс экспортлохыг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, импортолсон соёлын өвийг хураан авч, зэвсэгт мөргөлдөөн дуусахад буцаан өгөх, шударга эзэмшигчид урьд эзэлсэн улс нөхөн төлбөр олгох зэрэг асуудлыг манай улс хараахан нэгдээгүй Конвенцын I протоколд тусгасныг анхаарах хэрэгтэй. "Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах Конвенц" нь ЮНИДРУА-гийн Конвенцтой дэлхийн өвийн жагсаалт, дэлхийн соёлын өвийн жагсаалтад бүртгэгдсэн хөшөө дурсгал, археологийн цогцолбор, дурсгалт газар дэлхийн соёлын өвийг хадгалж, хамгаалах нийтлэг зарчмаар холбогдоно.

20. Олон улсын хэмжээнд соёлын үнэт зүйлийн хууль бус худалдаатай тэмцэх үндсэн гол баримт бичиг болон "Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай Конвенц"-д манай улс 1990 онд нэгдэн оржээ. Тус конвенцид нэмэлт дэмжлэг болох олон улсын баримт бичиг боловсруулах ЮНЕСКО-гийн хүсэлтээр ЮНИДРУА уг конвенцыг гаргасан учир конвенцууд нарийн уялджээ. Олон улсын хувийн эрх зүйн зохицуулалт бүхий хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаах асуудлыг илүү нарийн зохицуулсан 1995 оны Конвенц нь 1970 оны конвенцыг ерөнхий зарчим, үзэл санааг шүүхийн практикт бодитоор хэрэгжүүлэх боломжийг баталгаажуулжээ. Гэхдээ энэ 2 конвенц хоорондоо нийцэж нэг нэгнээ нөхөх боловч харин орлохгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

# ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

"Хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцыг соёрхон батлах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааны харьцуулалт, тайлбар болон нэгдсэн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг гаргалаа. Үүнд:

**1.** "Хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ын 3 дугаар бүлгийн 4 дүгээр зүйл (олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулах)-д заасны дагуу боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж батлах.

**2.** Конвенцын 16 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн соёлын эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэл, буцаах хүсэлтээ (a) шууд тухайн улсын шүүх болон эрх бүхий байгууллагад, (c) дипломат болон консулын шугамаар гаргах журмыг сонгож, мэдэгдэл (тайлбар)-ийг Олон улсын гэрээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т заасны дагуу конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөлд тусгай заалтаар оруулах.

**3.** Улсын хэмжээнд соёлын биет өвийг бүртгэх, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл болон түүх, соёлын үл хөдлөх дурсгалын зэрэглэл тогтоох болон алдагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх, гадаад улсад байгаа Монгол Улсын соёлын өвийг бүртгэн судлах, соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай арга хэмжээг авах.

**4.** Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт"-ын XXI хэсэгт түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх ялгааг "гаргах" гэж заасныг "гаргах, оруулах" болгох, зарим хүчингүй нэр томьёог хасч засварлах байдлаар журмын уг хэсгийг шинэчлэх.

**5.** Батламж жуух бичгийг гэрээний эд хадгалагчид өгснөөс 6 сарын дотор "Соёлын өвийг хамгаалах тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", "Гаалийн тухай хууль", "Эрүүгийн хууль", "Зөрчлийн тухай хууль" болон "Монгол Улсын хилээр тарифын бус бусад хязгаарлалттай нэвтрүүлэх бүлэг барааны жагсаалт", "Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт"-ын холбогдох хэсгийг, "Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам", "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам", "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам"-ыг бүхэлд нь англи, франц аль нэг хэлээр орчуулж, хүргүүлэхэд бэлтгэх.

**6.** Зэвсэгт мөргөлдөөний үед эзэлсэн тал, эзлэгдсэн улсын нутаг дэвсгэр дээр соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, зөөж нүүлгэх, эсвэл өмчлөх эрхийг шилжүүлэх, археологийн малтлага хийх, түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдолтой мэдээллийг устгах, нуун дарагдуулах зорилгоор соёлын үнэт зүйлийг өөрчлөхийг хориглох, эзэлсэн улсынхаа нутаг дэвсгэрээс хууль бусаар соёлын үнэт зүйлс экспортлохыг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, импортолсон соёлын өвийг хураан авч, зэвсэгт мөргөлдөөн дуусахад буцаан өгөх, шударга эзэмшигчид урьд эзэлсэн улс нөхөн төлбөр олгох асуудлыг зохицуулсан "Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай Конвенц"-ын I, II протоколд нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлэх.

7. "Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц" болон "Хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай конвенц"-уудыг тодорхой зорилтод бүлгүүд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

*Нэг. Олон улсын эрх зүйн баримт бичиг*

1. Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн Конвенц. 1886 он
2. "Соёлын үнэт зүйлийн худалдаа болон бусад холбогдох гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн шүүхийн шийдэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын удирдамж" 2014 он
3. Дипломат харилцааны тухай Венийн Конвенц. 1961 он
4. Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах Конвенц. 1972 он
5. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай Конвенц. 1954 он
6. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай Конвенцын нэмэлт I протокол 1954 он
7. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай Конвенцын нэмэлт II протокол 1999 он
8. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай Конвенц. 1954 он
9. Консулын харилцааны тухай Венийн Конвенц. 1963 он
10. Олон улсын гэрээний тухай Венийн Конвенц. 1969 он
11. Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай Конвенц. 1970 он
12. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенц. 2000 он
13. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1948 он
14. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт. 1966 он
15. ЮНЕСКО/ЮНИДРУА-гийн Илрээгүй соёлын эд зүйлсийн төрийн өмчлөлийн загвар заалтууд. 2011 он

*Хоёр. Монгол Улсын хууль тогтоомж*

*А.Хуулиуд:*

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
   /Шинэчилсэн найруулга/. 2012 он
   /Шинэчилсэн найруулга/. 2021 он
2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль. 2001 он
3. Арбитрын тухай хууль. /Шинэчилсэн найруулга/. 2017 он
4. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2020 он
5. Ашигт малтмалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2006 он
6. Аялал жуулчлалын тухай хууль. 2006 он
7. Бага дунд боловсролын тухай хууль. 2002 он
8. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
9. Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 1995 он
10. Барилгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2016 он
11. Гаалийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2008 он
12. Газрын тосны тухай хууль. /Шинэчилсэн найруулга/. 2014 он
13. Газрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2002 он
14. Газрын хэвлийн тухай хууль. 1988 он
15. Гамшигаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2017 он
16. Гүйцэтгэх ажлын тухай хууль. 1997 он

17. Дипломат албаны тухай хууль. 2000 он
18. Зар сурталчилгааны тухай хууль. 2002 он
19. Засгийн газрын тухай хууль. 1993 он
20. Зохиогчийн эрхийн тухай хууль. /Шинэчилсэн найруулга/. 2021 он
21. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017 он
22. Зөрчлийн тухай хууль. /Шинэчилсэн найруулга/. 2017 он
23. Иргэний хууль. 2002 он
24. Кино урлагийг дэмжих тухай хууль. 2021 он
25. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2020 он
26. Монгол Улсын Их хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2020 он
27. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль
28. Монгол Улсын шүүхийн тухай хууль. /Шинэчилсэн найруулга/. 2021 он
29. Монгол хэлний тухай хууль.
30. Музейн тухай хууль. 2021 он
31. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2021 он
32. Номын сангийн тухай хууль. 2014 он
33. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2015 он
34. Олон улсын гэрээний тухай хууль. /Шинэчилсэн найруулга/. 2016 он
35. Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2014 он
36. Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2021 он
37. Төр сүм хийдийн харилцааны тухай хууль. 1993 он
38. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль. 1996 он
39. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль. 1997 он
40. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль. 1994 он
41. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль. 2014 он
42. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2010 он
43. Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хууль. 2009 он
44. Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2008 он
45. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль. 1993 он
46. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2019 он
47. Хууль тогтоомжийн тухай хууль. /Шинэчилсэн найруулга/. 2015 он
48. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2006 он
49. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2017 он
50. Эрдэнэсийн сангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2022 он
51. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/. 2015 он
52. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2017 он

*Б. Бусад эрх зүйн актууд:*

53. "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолын хавсралт
54. "Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт" БСШУС-ын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалын хавсралт
55. "Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, зарцуулах, тайлагнах журам" Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 141 дүгээр тогтоолын хавсралт

56. “Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журам” Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 133 дугаар тогтоолын хавсралт
57. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 сарын 13 өдрийн 52 дугаар тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралт
58. “Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горим хэрэгжүүлэх журам” Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/41 дугаар тушаалын 2 дугаар хавсралт
59. “Бэлэг, дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам” Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
60. “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам” ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалын хавсралт
61. “Гаалийн хяналтын бүсийн журам” ГЕГ-ын даргын 2019 оны А/294 дүгээр тушаалын хавсралт
62. “Гамшигийн үед нүүлгэн шилжүүлэх журам” Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт
63. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
64. “Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал” Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралт
65. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 сарын 28-ны өдрийн 24 дугаар тогтоолын хавсралт
66. “Монгол улсын музейн сан хөмрөгийн дүрэм БСШУ-ны сайдын 2005 оны 11 дугаар сарын 8-ны өдрийн 347 дугаар тушаалын хавсралт
67. “Музейн сан хөмрөгийг бүртгэх баримтжуулах заавар” БСШУ-ны сайдын 2012 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/355 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
68. “Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам” Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолын хавсралт
69. “Соёлын өвийг хамгаалахад идэвх санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 343 дугаар тогтоолын хавсралт
70. “Соёлын өвийн судалгаа хийх журам” БСШУС-ын сайд, Сангийн сайдын 2015 оны А/141 дугаар тушаалын хавсралт
71. “Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” БСШУ-ны сайдын 2009 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 78 дугаар тушаалын хавсралт
72. “Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам” БСШУ-ны сайд, Дэд бүтцийн сайдын 2004 оны 5-р сарын 24-ний өдрийн 183/111 дугаар хамтарсан тушаалын хавсралт
73. “Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам” БСШУ-ны сайдын 2015 оны А/335 тушаалын 1 дүгээр хавсралт
74. “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт
75. “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 121 дүгээр тогтоолын хавсралт

76. "Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт" Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт
77. "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам" БСШУС-ын сайд, Сангийн сайдын 2019 оны А/237/92 дугаар тушаалын хавсралт
78. "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт
79. "Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед нүүлгэн шилжүүлэх журам" Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 288 дугаар тогтоолын хавсралт
80. "Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт" Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолын хавсралт
81. "Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт" Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт
82. "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам" Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт
83. "Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журам" ГЕГ-ын даргын 2008 оны 10 дугаар 10-ны өдрийн 660 дугаар тушаалын хавсралт
84. "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал" Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт
85. "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал" Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт
86. "Шүүхийн шийдвэрээр төрийн өмчлөлд шилжүүлсэн, гаалийн байгууллагад хураагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг соёлын өвийн сан хөмрөгт шилжүүлэх журам" Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 14 дүгээр тогтоолын хавсралт

*Гурав. Ном, эмхэтгэл, судалгааны материал*

*А.Монгол хэл дээр:*

1. Д.Майдар. Монголын түүх, соёлын дурсгалт зүйлс 8. Москва, Прогресс хэвлэлийн газар. 1981 он
2. Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000 он
3. ЮНЕСКО-гийн Бээжин дэх төлөөлөгчийн газар. ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс. "Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай бүсийн сургалт семинар" эмхтгэл, УБ хот. 2003 он
4. Соёлын өв судлал, бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлал, соёл урлагийн боловсрол" Соёлын чуулган уггсан хэлэлцүүлгийн эмхэтгэл. УБ, 2012 он
5. Ч.Доржсүрэн. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг. УБ, 2014 он
6. Х.Эрдэмбилэг. "Соёлын эд зүйлсийн эгүүлэг ба буцаалт: ЮНИДРУА-гийн Конвенц, УБ, 2018 он.
7. ХЗҮХ, ФСЭЗХ.Олон улсын гэрээний тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ, 2011 он

8. ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс. "ЮНЕСКО - Монакогийн хамтын ажиллагаа" Соёлын эд зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх чадавх дээшлүүлэх төсөл. Үр дүнгийн Тайлан 2009-2011 (I үе шат). УБ хот 2013 он
9. "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцид нэгдэн орохтой холбоотой эрх зүйн орчны судалгааны тайлан. УБ, 2016 он
10. БНМАУ-ын Бага хурлын хоёрдугаар чуулганы бичиг баримт. XXXI боть. Монгол Улс. Үндэсний төв архив. №2, №96 ХН:119. 1991.01.04.
11. "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенц. Монгол Улсын Гадаад харилцааны яам. Албан ёсны орчуулга, 2018.03.22
12. Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын мэдээлэл. 2021 он
13. ЭЦА-ны Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн танилцуулга. 2021 он
14. Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP сангийн мэдээлэл. 2021 он
15. ГЕГ-ын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын мэдээлэл. 2022 он
16. Цагдаагийн Ерөнхий Газрын Мэдээлэл, дүн шинжилгээний албаны мэдээлэл. 2022 он

*Б.Гадаад хэл дээр:*

17. Unidroit convention on stolen or illegally exported cultural objects. (Rome, 24 June 1995)
18. International Standards Section Division of Cultural Heritage "Legal and Practical Measures Against Illicit Trafficking in Cultural Property" UNESCO handbook., 2006
19. International Institute for the Unification of Private Law (UNIDROIT). Unidroit convention on stolen or illegally exported cultural objects and UNECO-UNIDROIT model provisions on state ownership of undiscovered cultural objects. Rome. 2013
20. Mission to Ulaanbaatar, Mongolia 24 to 26 June 2015 Report, Marina Schneider, Senior Officer, UNIDROIT

*Дөрөв. Цахим эх сурвалж*

1. https://legalinfo.mn/mn/law
2. https://www.unidroit.org/
3. https://whc.unesco.org/
4. http://assembly.coe.int/
5. http://ncch.gov.mn

**Хавсралт 1**

# МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН БИЕТ ӨВТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД

| Нэг. Олон улсын /олон талт/ гэрээнүүд | | | |
|---|---|---|---|
| **д/д** | **Гэрээний нэр, төрөл** | **Баталсан огноо** | **Нэгдэн орсон огноо** |
| 1 | "Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай Конвенц" | 1954 оны 5 дугаар сарын 14-ний өдөр баталж, 1956 оны 8 дугаар сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон. (Гаага) | 1964.11.04 |
| 2 | "Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах Конвенц" | ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 17 дугаар чуулганаар 1972.11.16-ны өдөр баталсан. (Парис) | 1990.02.02 |
| 3 | "Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр оруулах, гаргах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай Конвенц" | ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 16 дугаар чуулганаар 1970.11.14-ний өдөр баталсан. (Парис) | 1991.01.04 |

| Хоёр. Монгол Улсын хуулиуд | | | |
|---|---|---|---|
| **д/д** | **Хуулийн нэр** | **Батлагдсан огноо** | **Холбогдох зүйл, заалт** |
| 1 | Монгол Улсын Үндсэн хууль | 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр | Долдугаар зүйл.<br>1.Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.<br>2.Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн. |
| 2 | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль | 2001 оны 02 сарын 01-ний өдөр | 15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл<br>15.22.Соёлын чиглэлээр:<br>15.22.1.түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх;<br>15.22.2.соёлын өвийг сэргээн засварлах, палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх.<br>15.22.3.музейн үйл ажиллагаа эрхлэх. |
| 3 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2020 оны 04 сарын 24-ний өдөр | 6 дугаар зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага<br>6.1.Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 6.1.17.гадаад улсад байгаа Монгол Улсын үндэсний түүх, соёлд холбогдох архивын баримтыг судалж илрүүлэх, шилжүүлж авах ажлыг зохион байгуулах;<br>10 дугаар зүйл.Үндэсний архивын сан хөмрөгийн бүрэлдэхүүн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 10.1.Үндэсний архивын сан хөмрөг нь төрийн ой санамж, Монгол Улсын түүх, соёлын өв болохын хувьд өмчийн хэлбэрээс үл хамааран төрийн хамгаалалтад байна.<br>11 дүгээр зүйл.Архивын баримтын зэрэглэл<br>11.1.Архивын баримтыг хосгүй үнэт, нэн үнэт, үнэт, өрдийн гэж зэрэглэнэ.<br>11.2.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.3-т заасан шалгуурыг хангасан архивын баримтыг хосгүй үнэт баримтад хамруулна.<br>11.3.Түүх, соёлын болон шинжлэх ухааны хувьд онцгой ач холбогдолтой, бүртгэл, хадгалалт, ашиглалтын тусгай нөхцөл шаардагдах архивын баримтыг нэн үнэт баримтад хамруулна.<br>11.4.Үнэт баримтад хосгүй үнэт, нэн үнэт баримт гэж тогтоосноос бусад буюу энэ хуулийн 6.1.11-д заасан жагсаалтад байнга хадгалахаар тусгасан архивын баримт хамаарна.<br>11.9.Хосгүй үнэт архивын баримттай холбогдох энэ хуульд заагаагүй бусад асуудлыг Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу зохицуулна. |
| 4 | Ашигт малтмалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2006 оны 07 сарын 08-ны өдөр | $40^1$ дүгээр зүйл.Соёлын өвийг хамгаалах<br>$40^1$.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 402, 46 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ.<br>$40^1$.2.Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.<br>$40^2$ дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг<br>$40^2$.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь соёлын өвийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:<br>$40^2$.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, улсын хяналтын байцаагчид хайгуулын талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх боломжоо олгох;<br>$40^2$.1.2.ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуульд заасны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх ба тухайн өвийг холбогдох байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ.<br>41 дүгээр зүйл. Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх<br>41.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна. |
| 5 | Аялал жуулчлалын тухай хууль | 2000 оны 5 дугаар сарын 05-ны өдөр | 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо<br>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.3. "аялал жуулчлалын бүс нутаг" гэж Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэхэд тохирсон байгаль, түүх, соёлын нөөц бүхий газар нутгийг;<br>8 дугаар зүйл. Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх<br>8.1. Аялал жуулчлалын байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.1.5. байгаль, түүх, соёлын нэн ховор зүйлсийг хайрлан хамгаалахад өөрийн зүгээс шаардагдах арга хэмжээ авах, гарсан зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэх; |
| 6 | Бага дунд боловсролын тухай хууль | 2002 оны 5 дугаар сарын 03-ны өдөр | 5 дугаар зүйл.Суурь боловсролын агуулга<br>5.1.Суурь боловсролын агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:<br>5.1.2.гоо зүй, ёс суртахууны соёлтой, эрүүл чийрэг, иргэний үүргээ ухамсарласан, үнэнч шударга, хамтач, энэрэнгүй, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахидаг, үндэсний болон хүн төрөлхтний дэвшилт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг хүндлэн хайрладаг болгон төлөвшүүлэх; |
| 7 | Байгаль орчныг хамгаалах тухай хууль | 1995 оны 3 дугаар сарын 30-ны өдөр | 47 дугаар зүйл. Байгалийн нөөцийн хамтын менежментийн хамрах хүрээ<br>1.Нөхөрлөлийн хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх объектэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгалийн нөөцөөс гадна дэлхийн болон үндэсний байгаль, соёлын өвд хамаарагдах газар нутаг орно. |
| 8 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр | 8 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ<br>8.4.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана: 8.4.9.төсөл хэрэгжих газрын түүх соёлын үнэт зүйлс, төслийн онцлогтой уялдсан бусад асуудал. |
| 9 | Барилгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр | 37 дугаар зүйл. Захиалагчийн чиг үүрэг<br>37.1.Барилгын ажлын захиалагч дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:37.1.11.түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэх, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах;<br>40 дүгээр зүйл. Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг<br>40.1.Барилгын ажил гүйцэтгэгч дараахь чиг үүрэгтэй:<br>40.1.4.барилгын ажлын талбайд гал, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны горимыг мөрдөж, байгаль орчин, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах;<br>46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 46.1.Барилга байгууламжийн ашиглалтын явцад өмчлөгч, эзэмшигч дараахь үүргийг хүлээнэ:<br>46.1.6.байгаль орчин, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах; |
| 10 | Гаалийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр | 209 дүгээр зүйл. Устгах горимд үл байршуулах бараа<br>209.1.Дор дурдсанаас бусад барааг устгах горимд байршуулж болно:<br>209.1.1.түүх, соёлын дурсгалт зүйл;<br>246 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг шалгах<br>246.5.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь дараахь барааг мэдүүлэгчийг байлцуулахгүйгээр шалгаж болно:<br>246.5.1.нийтийн аюулгүй байдал, хүн ам, ургамал, амьтан, хүрээлэн буй орчинд аюул учруулж болохуйц тэсэрч дэлбэрэх, түргэн шатах бараа, цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, түүх, соёлын үнэт зүйлс; |
| 11 | Газрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2002 оны 6 дугаар сарын 07-ны өдөр | 16 дугаар зүйл.Тусгай хэрэгцээний газар<br>16.1.Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Улсын тусгай хэрэгцээний газарт дараахь газар хамаарна:<br>16.1.15.хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар.<br>50 дугаар зүйл.Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах нийтлэг шаардлага<br>50.1.Газар эзэмшигч, ашиглагч нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар дараахь шаардлагыг биелүүлнэ:<br>50.1.4.ойн төгөл, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хамгаалах; |
| 12 | Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр | 11 дүгээр зүйл.Гэрээлэгчийн эрх, үүрэг<br>11.1.Гэрээлэгч дараах эрх эдэлнэ:<br>11.2.15.үйл ажиллагааных нь явцад түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд тухайн газарт явуулж байгаа үйл ажиллагаагаа зогсоон, нэн даруй холбогдох байгууллагад мэдэгдэх;<br>40 дүгээр зүйл.Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх<br>40.1.Гэрээлэгч нь хайгуул, ашиглалтын явцад худаг, өвөлжөө, намаржаа, хаваржаа, хувийн болон нийтийн зориулалттай орон байр, бусад барилга байгууламж, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг бусдын өмчлөл, эзэмшлийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол хохирлыг нь бүрэн хэмжээгээр нөхөн төлнө. |
| 13 | Газрын хэвлийн тухай хууль | 1988 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр | 20 дугаар зүйл.Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг<br>2.Газрын хэвлийг ашиглагч нь дор дурдсан шаардлагыг хангах үүрэгтэй:<br>3/газрын хэвлийг ашиглахад үүсч болзошгүй хортой нөлөөнөөс хий мандлын агаар, газар, ой, |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ус, рашаан, мал ан амьтан, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг найдвартай хамгаалах, түүнчлэн тусгай хамгаалалттай газар, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг хангах;<br>5/газрын хэвлийг ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу болон шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах.<br>43 дугаар зүйл.Шинжлэх ухаан, түүх, соёлын онцгой үнэт зүйлийг агуулсан газрын хэвлийн хэсгийг хамгаалах<br>1.Геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, палеонтологийн болон шинжлэх ухаан, түүх, соёлын хувьд онцгой үнэт зүйл бүхий газрын хэвлийн хэсгийг төрийн хамгаалалтад авна. Төрийн хамгаалалтад авсан газрын хэвлийн хэсгийн бүрэн бүтэн байдалд харшлах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.<br>2.Газрын хэвлийг ашиглах явцад геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, солир, палеонтологи, археологийн болон шинжлэх ухаан, түүх соёлын хувьд сонирхол татах бусад зүйл илэрвэл газрын хэвлийг ашиглагчид ажлаа зогсоож, энэ тухай төрийн зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. |
| 14 | Гамшигаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2017 оны 02 сарын 02 өдөр | 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.1.“гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;<br>4.1.5."аюул" гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг;<br>4.1.10.“эрэн хайх, аврах ажиллагаа” гэж голомтын бүсэд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх арга хэмжээг;<br>19 дүгээр зүйл.Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх<br>19.1.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ. |
| 15 | Гүйцэтгэх ажлын тухай хууль | 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдөр | 9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага<br>9.1.Дараахь байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй: 9.1.3.цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, ...алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсрэх |

| | | | |
|---|---|---|---|
| | | | дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох;<br>12 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил явуулах хүрээ<br>12.1.Гүйцэтгэх ажил дараах хүрээгээр хязгаарлагдана:<br>12.1.6.алдагдсан нууц бичиг баримт, эд зүйл, галт хэрэгсэл, зэвсэг, тэсрэх болон хүчтэй хордуулах, цацраг идэвхт, мансууруулах бодис, түүх, соёлын дурсгалт зүйл, нуугдмал эд хөрөнгийг эрж олох; |
| 16 | Зар сурталчилгааны тухай хууль | 2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр | 7 дугаар зүйл.Хууль бус зар сурталчилгаа<br>7.4.Дараах зар сурталчилгааг ёс суртахуунд үл нийцсэнд тооцно:<br>7.4.4.үндэсний болон түүх, соёлын үнэт зүйлсийн бүртгэлд орсон урлагийн бүтээлийг гутаан доромжилсон; |
| 17 | Засгийн газрын тухай хууль | 1993 оны 5 дугаар сарын 06-ны өдөр | 9 дүгээр зүйл. Нийгмийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амын нийгмийн хамгаалалтын талаархи Засгийн газрын бүрэн эрх<br>2.Ард түмний оюуны өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, уламжлалт зан заншлыг дэмжин хөгжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.<br>20 дугаар зүйл.Засгийн газрын бүрэлдэхүүн<br>5.Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:<br>13/Соёлын сайд:<br>-түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого; |
| 18 | Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр | 7.10 дугаар зүйл.Газрын хэвлийн тухай хууль зөрчих<br>4.Газрын хэвлийг:<br>4.2.ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй;<br>4.3.ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>7.13 дугаар зүйл.Газрын тосны тухай хууль зөрчих<br>16.Гэрээлэгч: 16.7.үйл ажиллагааных нь явцад түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд тухайн газарт явуулж байгаа үйл ажиллагаагаа зогсоож холбогдох байгууллагад даруй мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 1.Хуульд заасны дагуу:<br>1.1.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, эсхүл уг сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй;<br>1.2.соёлын өвийг хуульд заасан хугацаанд бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй;<br>1.3.соёлын өвийг зөөж тээвэрлэх журам зөрчсөн;<br>1.4.түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хураах хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>2.Соёлын өвийн судалгаа, шинжилгээ хийхдээ язгуур шинж, унаган төрх байдал, хүрээлэн байгаа орчны зохиомжийг эвдэж хуулиар тогтоосон журам, эсхүл стандартыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>3.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавихгүйгээр худалдсан, эсхүл гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлсэн, эсхүл зуучилсан бол уг дурсгалт зүйлийг хураан авч улсын орлого болгон хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>4.Соёлын биет өвийг сэргээн засварлах хуулиар тогтоосон журам, эсхүл стандартыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>5.Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хуулиар тогтоосон хориглолт, журам, стандартыг зөрчсөн, эсхүл анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан, эсхүл зөвшөөрөлгүй хөдөлгөж, зөөж тээвэрлэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>6.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэргэд байрлуулсан танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээг эвдэж устгасан, эсхүл дурсгал дээр ханын самбар, зурагт хуудас, түүнтэй адилтгах бусад хэрэгслийг байрлуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>7.Соёлын өвийн, эсхүл түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын дэглэм зөрчсөн бол хүнийг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>8.Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад илэрсэн соёлын биет өвийг хамгаалах, мэдээлэх арга хэмжээ аваагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>9.Нийтийн өмчийн соёлын биет өвийг 1:1 масштабаар зөвшөөрөлгүй хувилан олшруулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>10.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийхдээ:<br>10.1.геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, усны эх, рашаан, булаг, бүрд зэрэг байгалийн унаган тогтоц, эмзэг хэсгийг гэмтээсэн;<br>10.2.тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэсэн;<br>10.3.судалгааны үр дүнд хохирол учруулж болзошгүй техник, тоног төхөөрөмж ашигласан;<br>10.4.малтлага, судалгааны явцад үүссэн нүх, хонхор болон хүрээлэн байгаа орчны үзэмжийг эвдсэн элс, шороо, чулуун овоолго үлдээсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>11.Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа түүний анхны төрх байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж гэмтээсэн, олдворыг стандартын шаардлага хангаагүй өрөө тасалгаа, орчинд хадгалсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>12.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээсэн, эсхүл үрэгдүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.<br>13.Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын болон орчны бүсэд хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 14.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй палеонтологи, археологийн олдвор, дурсгалаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үзэсгэлэн гаргасан, эсхүл музей байгуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгож хүнийг зургаан зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. |
| 19 | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль | 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр | 4.5 дугаар зүйл.Эд зүйл, баримт бичиг хураан авах 4.Зарим онцлох эд зүйл, үнэт эдлэл, түүх, соёлын дурсгалт зүйл, тэсрэх дэлбэрэх, хордуулах бодисыг хураан авах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулж, эсхүл мэргэжлийн байгууллагад хандан гүйцэтгүүлж болно. |
| 20 | Иргэний хууль | 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр | 118 дугаар зүйл. Дарагдмал үнэт зүйл<br>118.3.Дарагдмал үнэт зүйлс дотор түүх, соёлын дурсгалт зүйл байвал тэдгээрийг төрийн өмчлөлд шилжүүлнэ. Энэ тохиолдолд дарагдмал үнэт зүйл олдсон газрын буюу эд хөрөнгийн өмчлөгч болон эд юмсыг олсон этгээдэд түүний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх мөнгөн шагналыг тэнцүү хувааж олгоно.<br>118.4.Хайгуул, малталт хийх албан үүрэг бүхий этгээд уг үүргээ гүйцэтгэх явцдаа илрүүлсэн дарагдмал үнэт зүйлс, археологийн болон палентологийн олдворт энэ зүйлд заасан журам хамаарахгүй. |
| 21 | Кино урлагийг дэмжих тухай | 2021 оны 07 сарын 02 өдөр | 20 дугаар зүйл.Кино зураг авалт хийх зөвшөөрөл<br>20.6. Түүх, соёлын дурсгалт газар, тусгай хамгаалалттай газар нутагт кино зураг авалт хийхэд Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан журмыг баримтална. |
| 22 | Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2020 оны 05 сарын 07 өдөр | 24 дүгээр зүйл.Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ<br>24.3.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо:<br>24.3.3.ард түмний түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого; |
| 23 | Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2020 оны 12 сарын 24 өдөр | 21 дүгээр зүйл.Аймгийн чиг үүрэг<br>21.1.Аймгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:<br>21.1.12.хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт;<br>21.1.16.мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, нэгдсэн эмнэлэг, аймгийн музей, театр, номын сан, соёлын ордон, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар.<br>22 дугаар зүйл.Сумын чиг үүрэг<br>22.1.Сумын чиг үүрэгт дараах асуудал хамаарна:<br>22.1.17.сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар; |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 24 дүгээр зүйл.Нийслэлийн чиг үүрэг<br>24.1.Нийслэлийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:<br>24.1.8.нийслэлийн музей, театр, номын сан, соёлын ордон, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;<br>24.1.18.хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт;<br>25 дугаар зүйл.Дүүргийн чиг үүрэг<br>25.1.Дүүргийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:<br>25.1.8.дүүргийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;<br>27 дугаар зүйл. Нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэг<br>27.5.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ:<br>27.5.19.түүхэн дурсгалт зүйлийн хамгаалалт; |
| 24 | Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2021 оны 07 сарын 07 өдөр | 8 дугаар зүйл.Нийслэл хотын чиг үүрэг<br>8.1.Нийслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24.1-д зааснаас гадна нийслэл хот болохын хувьд энэ хуульд заасан тусгай болон бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.<br>8.2.Нийслэл хот нь дараах тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ:<br>8.2.4.нийслэл дэх үндэсний хэмжээний түүх, соёлын дурсгалт газрын хадгалалт, хамгаалалт; |
| 25 | Монгол хэлний тухай хууль | 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр | 5 дугаар зүйл.Хуулийн үндсэн зарчим<br>5.1.Монгол хэл нь монгол үндэстний оюуны соёлын үнэт өв, үндэсний соёл иргэншлийн язгуур үндэс, улс орны нэгдмэл байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын нэгэн баталгаа мөн.<br>14 дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага<br>14.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:<br>14.1.1.монгол хэл, бичгийн соёлын өвийг хамгаалах, үндэсний монгол бичгээрх оюуны өв сан, ардын аман зохиол болон монгол утга зохиолын судалгаа, сургалтыг өргөжүүлэх ажлыг боловсролын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх; |
| 26 | Музейн тухай хууль | 2021 оны 01 сарын 29 өдөр | 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт<br>1.1.Энэ хуулийн зорилт нь музейн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, музейн сан хөмрөг бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.<br>2 дугаар зүйл.Музейн хууль тогтоомж<br>2.1.Музейн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Соёлын тухай |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. |
| 27 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2021 оны 12 сарын 17 өдөр | 9 дүгээр зүйл.Хязгаарлалттай мэдээлэл<br>9.2.Энэ хуулийн 7.3-т /танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж үзнэ/ заасан хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна: 9.2.3.нээлттэй байлгах нь соёлын хосгүй үнэт өвд аюул учруулж болзошгүй мэдээлэл; |
| 28 | Номын сангийн тухай хууль | 2014 оны 12 сарын 19 өдөр | 6 дугаар зүйл. Номын сангийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн эрх, үүрэг<br>6.2.5.Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах судар болон хуучин ном, гар бичмэлийг сурвалжлан олох, нөхөн бүрдүүлэх, олон нийтэд сурталчлах, хадгалах, хамгаалах хэвийн нөхцөлийг хангаж ажиллах;<br>7 дугаар зүйл.Үндэсний номын сангийн эрх зүйн байдал<br>7.1.Монгол Улсын Үндэсний номын сан /цаашид "Үндэсний номын сан" гэх/ нь монголын ард түмний бичиг үсгийн дурсгалыг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үүрэг бүхий байгууллага байна.<br>9 дүгээр зүйл.Үндэсний номын сангийн үүрэг<br>9.4.1.түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах ном, судрыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу бүртгүүлж, хамгаалах;<br>14 дүгээр зүйл.Номын сангийн уншигчийн эрх, үүрэг<br>14.1.Уншигч нь Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлд хамаарах болон ганц хувь бүтээл, гар бичмэл, зохиогчийн эрхэд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээлээс бусад хэвлэлийн бүтээгдэхүүнийг чөлөөтэй ашиглана.<br>14.2.Энэ хуулийн 14.1-д заасан хэвлэлийн бүтээгдэхүүнийг ашиглах асуудлыг Соёлын өвийг хамгаалах тухай, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.<br>20 дугаар зүйл. Номын сангийн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт<br>20.2.Түүх, соёлын дурсгалт зүйлийн хосгүй үнэт, үнэт зэрэглэлд хамаарах болон ганц хувь бүтээлийг цахим хэлбэрт оруулж баримтын хамгаалалтын хувь хийж, эх баримтаас тусад нь хадгална.<br>20.3.Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах болон ганц хувь бүтээл, гар бичмэлийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу бүртгүүлж, хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг хангасан байх бөгөөд энэхүү шаардлагыг хангах |

| | | | |
|---|---|---|---|
| | | | боломжгүй тохиолдолд Үндэсний номын санд нэн даруй шилжүүлэн хадгалуулж, хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлсний дараа буцаан шилжүүлнэ. |
| 29 | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдөр | 13 дугаар зүйл.Албан татвараас чөлөөлөх<br>13.1.Дараах барааг албан татвараас чөлөөлнө:<br>13.1.22.соёлын өвийг судалж шинжлэх, сэргээн засварлахад ашиглах материал, техник, тоног төхөөрөмж, бодис, багаж хэрэгсэл;<br>13.5.Дараах үйлчилгээг албан татвараас чөлөөлнө:<br>13.5.15.соёлын өвийг сэргээн засварлах үйлчилгээ; |
| 30 | Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2021 оны 07 сарын 02 өдөр | 3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт<br>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:<br>3.1.1."соёлын үнэт зүйл" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах, эсхүл хүний оюун санаа, үйлдэхүйн үр дүнд бий болсон соёлын агуулга бүхий биет болон биет бус илэрхийллийг;<br>4 дүгээр зүйл.Төрөөс соёлын талаар баримтлах бодлого<br>4.1.Төрөөс соёлын талаар дараах бодлого хэрэгжүүлнэ:<br>4.1.1.соёлын өвийг төрийн онцгой анхаарал, ивээлд байлгах;<br>8 дугаар зүйл.Төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх соёлын үйл ажиллагааны чиглэл<br>8.5.Монголын соёлын давтагдашгүй хэв шинж, уламжлалт мэдлэг, сэтгэлгээний илэрхийлэл болсон соёлын өвийг хамгаалж, баталгаажуулна.<br>9 дүгээр зүйл.Соёлын үйл ажиллагааны чиглэл<br>9.1.Соёлын үйл ажиллагааг дараах чиглэлээр явуулна:<br>9.1.1.соёлын өвийг хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа;<br>9.2.Соёлын өвийг хамгаалахтай холбогдсон харилцааг Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар нарийвчлан зохицуулна.<br>12 дугаар зүйл.Соёлын үнэт зүйлийн бүртгэл<br>12.1.Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах чиг үүргийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.<br>12.2.Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.<br>12.3.Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан соёлын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр төрөлжсөн мэдээллийн сангаас бүрдэх бөгөөд төрөлжсөн мэдээллийн сангийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | үйл ажиллагааг холбогдох хууль болон энэ хуулийн 12.2-т заасан журмаар зохицуулна.<br>12.4.Гадаад улсад байгаа монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийг үндэсний бүртгэл, мэдээллийн санд бүртгэж болно.<br>13 дугаар зүйл.Соёлын үнэт зүйлийн үнэлгээ<br>13.1.Соёлын үнэт зүйлийг Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан журмын дагуу үнэлнэ.<br>27 дугаар зүйл.Олон улсын хамтын ажиллагаа<br>27.1.Олон улсын хамтын ажиллагааг дараах чиглэлээр дэмжиж, хөгжүүлнэ:<br>27.1.1.монголын түүх, соёлд холбогдох соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх, хадгалж хамгаалах талаар уг өв байгаа улстай хамтран ажиллах;<br>27.1.2.монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийн хуулбарыг авчрах;<br>27.1.3.хууль бусаар алдагдсан соёлын өвийг эргүүлэн авчрах;<br>27.1.4.монголын түүх, соёлыг гадаадад сурталчлах;<br>27.1.5.соёлын биет өвийг сэргээн засварлах;<br>32 дугаар зүйл.Соёлын үйл ажиллагааны санхүүжилт<br>32.6.Соёлын үйл ажиллагааг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор иргэн, хуулийн этгээдээс оруулсан хандив, хөрөнгө оруулалтад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх журмыг холбогдох хуулиар тогтооно.<br>35 дугаар зүйл.Мерчандайзийн гэрээ<br>35.3.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг олгоно:<br>35.3.1.төрийн өмчийн соёлын байгууллагын эзэмшиж байгаа соёлын үнэт зүйл, урлагийн бүтээл, соёлын биет өв;<br>35.3.2.төрийн өмчийн музейд хадгалагдаж байгаа үзмэр;<br>35.3.3.түүх, соёлын үл хөдлөх дурсгал.<br>35.4.Энэ хуулийн 35.3-т зааснаас бусад орон нутгийн өмчийн соёлын үнэт зүйл, урлагийн бүтээлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг тухайн шатны Засаг дарга олгоно.<br>35.5.Энэ хуулийн 35.3-т зааснаас бусад төрийн өмчийн байгууллагын эзэмшиж байгаа соёлын үнэт зүйл, урлагийн бүтээлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно. |
| 31 | Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдөр | 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт<br>1.1.Энэ хуулийн зорилт нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 2 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж<br>2.1.Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.<br>2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. |
| 32 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль | 1996 оны 5 дугаар сарын 27-ны өдөр | 4 дүгээр зүйл. Төрийн нийтийн зориулалттай өмч<br>1.Үндсэн хууль, бусад хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар бүх ард түмний өмч болгон заасан зүйлсийг төрийн нийтийн зориулалттай өмч гэнэ.<br>2.Төрийн нийтийн зориулалттай өмчид дараахь үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө хамаарна:<br>6/ түүх, соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал;<br>7/ археологийн болон палентологийн олдвор; |
| 33 | Төр сүм хийдийн харилцааны тухай хууль | 1993 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр | 11 дүгээр зүйл.Сүм хийдийн өмч, аж ахуйн харилцааг зохицуулах<br>2.Сүм хийд өөрийн эзэмшилд болон өмчлөлд байгаа газраас үл салах түүх, соёлын үл хөдлөх дурсгал, бусад үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд, дурсгалын талаарх мэдээллийг соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлнэ. |
| 34 | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль | 1994 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр | 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт<br>Энэ хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх,соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах,танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.<br>22 дугаар зүйл. Дурсгалт газар<br>Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дурсгалт газар гэнэ.<br>23 дугаар зүйл. Дурсгалт газрын төрөл<br>1. Дурсгалт газрыг дараахь төрөлд хуваана:<br>1/ байгалийн дурсгалт газар;<br>2/ түүх, соёлын дурсгалт газар;<br>3/дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газар. 2. Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, эртний ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл, давхаргазүйн тулгуур зүсэлт зэрэг эрдэс чулуулгийн ховор олдвор,хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, төгөл мод, рашаан булаг, баянбүрд, элсэн манхан, солир, солирын |

| | | | |
|---|---|---|---|
| | | | цар, ерх, галт уулын тогоо зэргийг хамааруулж болно.<br>3. Түүх, соёлын дурсгалт газарт эртний хүний оромж, отог, сууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш бунхан, эртний хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамааруулж болно.<br>26 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх<br>Засгийн газар тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>6/ байгалийн нөөц газрын болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох.<br>29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх<br>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>3/ байгалийн нөөц газар, дурсгалт газрын хамгаалалтыг эрхлэх. |
| 34 | Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль | 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдөр | 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт<br>1.1.Энэ хуулийн зорилт нь тусгай хамгаалалттай газар нутагт орчны бүсийг тогтоох, орчны бүсэд үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.<br>3 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс<br>3.2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шаардлагатай гэж үзвэл байгалийн нөөц газар, дурсгалт газарт орчны бүс, түүний заагийг тогтоож болно.<br>4 дүгээр зүйл.Орчны бүсийг тогтоох шалгуур<br>4.1.Дараахь шалгуурыг харгалзан орчны бүсийг тогтооно: 4.1.3.Бусад шалгуур:<br>4.1.3.б.түүх, соёлын дурсгалт зүйлс бүхий газар нутаг. |
| 36 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль | 2014 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр | 8 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх<br>8.2.Улсын тусгай хамгаалалттай болон түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газраас бусад тусгай хэрэгцээний газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах асуудлыг шийдвэрлэнэ.<br>25 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг<br>25.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглахдаа энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг биелүүлж ажиллах бөгөөд зөрчвөл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.<br>25.4.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах явцад өөр төрлийн ашигт малтмал, түүх, соёлын олдвор, эд |

| | | | |
|---|---|---|---|
| | | | өлгийн зүйл илэрсэн тохиолдолд үйл ажиллагаагаа зогсоож аймаг, нийслэлийн Засаг даргад мэдэгдэнэ.<br>25.5.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.10-т заасан шаардлагыг хангаж ажиллана. |
| 37 | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр | 5 дугаар зүйл. Тэмдэгтийн хураамж хураах үйлчилгээний төрөл<br>5.1.Тэмдэгтийн хураамжийг дор дурдсан үйлчилгээнд хураана:<br>5.1.25.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.6-д заасны дагуу гэрчилгээ олгох, мөн хуулийн 9.4, 10.5, 11.3, 17.10, 20.1, 20.3-т заасан үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох;<br>22[1]дүгээр зүйл.Соёлын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ<br>22[1].1.Соёлын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:<br>22[1].1.1.түүх, соёлын хосгүй үнэт зүйлийг бүртгэх, гэрчилгээ олгоход 1000-2000 төгрөг;<br>22[1].1.2.хот, суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход археологи, палеонтологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл олгоход 40 000-300 000 төгрөг;<br>22[1].1.3.соёлын өвийг хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 20 000-50 000 төгрөг, шаардлагатай бол хугацааг сунгахад 12 000-30 000 төгрөг.<br>22[1].1.4.соёлын өвийг сэргээн засварлах, палентологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл олгоход 300 000-500 000 төгрөг.<br>28 дугаар зүйл.Барилга, хот байгуулалтын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ<br>28.1.Барилга, хот байгуулалтын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:<br>28.1.9.барилгын засвар үйлчилгээ, орчны тохижилт, түүх, соёлын барилга, мод ба өрөгт бүтээцэн барилга, барилгын өргөтгөл шинэтгэл, барилгын доторх инженер, цахилгаан хангамж, гал, холбоо дохиоллын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 80 000-200 000 төгрөг.<br>41 дүгээр зүйл.Тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 41.4.Дараахь үйлчилгээг тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө:<br>41.4.15.түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлагаа, судалгаа хийх үйл ажиллагаа. |
| 38 | Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хууль | 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | 44 дүгээр зүйл.Барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдах<br>44.4.Дараахь барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдахыг хориглоно:<br>44.4.2.улсын бүртгэлд бүртгүүлсэн буюу бүртгүүлвэл зохих үл хөдлөх хөрөнгө болох түүх, урлаг, соёлын үнэт зүйлс. |
| 39 | Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль | 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдөр | 21 дүгээр зүйл. Оршин суугчдын нийгмийн хамгаалалт болон ахуйн соёлын хэрэгцээг хангах талаархи хот, тосгоны захирагчийн бүрэн эрх<br>5.Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалж, тэдгээрийн ашиглалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна. |
| 40 | Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр | 12 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичигт тавигдах шаардлага<br>12.4.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь дараахь шаардлагыг хангасан байна:<br>12.4.1.хүн амын амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн, хот, тосгоны хөгжлийн чиглэлийг тодорхойлсон, хот, тосгоны хил хязгаар, газар нутгийн үүргийн бүсчлэл, инженер, зам тээвэр болон нийгмийн дэд бүтцийн хөгжил, түүх, соёлын дурсгалт байгууламж, архитектур-хот байгуулалтын шаардлага, экологийн болон эрүүл ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байх;<br>23 дугаар зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлах<br>23.1.Дараахь бүсэд хэрэгжүүлэх хот байгуулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтооно:<br>23.1.1.түүх, соёлын дурсгалт барилга байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд; |
| 41 | Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2019 оны 03 сарын 22 өдөр | 23 дугаар зүйл.Албан татварын хөнгөлөлт<br>23.8.Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулж өгсөн баримтаар нотлогдож байгаа хандивтай тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг албан татвар төлөгчид эдлүүлнэ. |
| 42 | Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2006 оны 12 дугаар сарын 28-ны өдөр | 11 дүгээр зүйл. Эрдэм шинжилгээний байгууллага<br>11.2. Эрдэм шинжилгээний байгууллагыг дор дурдсан хэлбэрээр байгуулж болно:<br>11.2.4.төрийн болон орон нутгийн музей, үндэсний соёлын байгууллага. |
| 43 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр | 54 дүгээр зүйл.Төлбөр төлөгчийн хөрөнгийг хураах<br>54.7.Үндэсний мөнгөн тэмдэгт, гадаад валют, үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрийг оролцуулан бүтээсэн үнэт эдлэл, түүх, соёлын |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хосгүй болон бусад үнэт, дурсгалт зүйлийг хураан авна.<br>54.8.Хураан авсан үндэсний мөнгөн тэмдэгт, гадаад валютыг хураан авснаас хойш 24 цагийн дотор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын банкан дахь дансанд, үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрийг оролцуулан бүтээсэн үнэт эдлэл, түүх соёлын хосгүй болон бусад үнэт, дурсгалт зүйлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үнэ бүхий эд зүйл хадгалах тусгай зориулалтын байранд даруй шилжүүлнэ.<br>55.2.Дараахь хөрөнгийг шинжээчээр үнэлүүлнэ:<br>55.2.3.үнэт металл, эрдэнийн чулуу;<br>55.2.4.бүх төрлийн цуглуулга;<br>55.2.5.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан түүх, соёлын өв, дурсгалд хамаарах эд зүйл;<br>65 дугаар зүйл.Албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулах<br>65.1.Төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, эдийн бус хөрөнгө, түүх, соёлын өвд хамаарах үнэт зүйл, тусгай зөвшөөрлийг энэ хуульд заасны дагуу хөрөнгийн албадан дуудлага худалдаа /цаашид "дуудлага худалдаа" гэх/-гаар худалдан борлуулна. |
| 44 | Эрдэнэсийн сангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2022 оны 04 сарын 22 өдөр | 3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт<br>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:<br>3.1.1."эрдэнэс" гэж түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл, байгалийн төрцийг;<br>4 дүгээр зүйл.Эрдэнэсийн сан, түүний ангилал<br>4.3.Үндсэн сан байнгын болон байнгын бус хэсгээс бүрдэнэ.<br>4.4.Үндсэн сангийн байнгын хэсэгт Монгол Улсын хуваагдашгүй өмч болох эрдэнэс байх бөгөөд тэдгээрийг худалдах, шилжүүлэх, захиран зарцуулахыг хориглоно.<br>4.5.Үндсэн сангийн байнгын бус хэсэгт олон улсын жишгээр цэвэршүүлсэн үнэт металл, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх, соёлын үнэт дурсгалт зүйл, үнэт болон бусад металлаар хийж нөөцөд авсан зоос байна.<br>4.6.Үндсэн сангийн байнгын хэсэгт байх түүх, соёлын дурсгалт зүйл нь хосгүй үнэт зэрэглэлтэй байна.<br>6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх<br>6.1.2.Монголбанкны хүсэлтийн дагуу түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг Эрдэнэсийн санд шилжүүлэх шийдвэр гаргах;<br>15 дугаар зүйл. Хүн, хуулийн этгээд, бусад байгууллагын эрх, үүрэг<br>15.3.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монголбанкны |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хүсэлтийн дагуу түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийн бүртгэл, мэдээллийг гаргаж өгнө. |
| 45 | Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ | 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр | 17.1 дүгээр зүйл.Хулгайлах<br>2.Энэ гэмт хэргийг:<br>2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж... үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>18.5 дугаар зүйл.Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх<br>3.Энэ гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>Хорин тавдугаар бүлэг.Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг<br>25.1 дүгээр зүйл.Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах<br>1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.<br>2.Үнэт зэрэглэлд хамаарах түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Хосгүй үнэт зэрэглэлд хамаарах түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>25.2 дугаар зүйл.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах<br>1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл |

| | | | |
|---|---|---|---|
| | | | нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.<br>2.Улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан, эсхүл энэ гэмт хэргийг олон хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болох аргаар үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.<br>25.3 дугаар зүйл.Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх<br>1.Соёлын биет өвийг завшсан, үрэгдүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>25.4 дүгээр зүйл.Хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийх<br>1.Хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага, судалгаа хийсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Хууль бус археологи, палентологийн хайгуул, малтлага, судалгааг санхүүжүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.<br>25.5 дугаар зүйл.Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах<br>1.Соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 2.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>25.6 дугаар зүйл.Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх<br>1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй, эсхүл түүх, соёлын дурсгалт зүйлийг завшсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>25.7 дугаар зүйл.Эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах<br>1.Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр Эрдэнэсийн сангийн байнгын бус хэсгээс эрдэнэсийг худалдсан, шилжүүлсэн, захиран зарцуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Эрдэнэсийн сангийн байнгын хэсгээс эрдэнэсийг худалдсан, шилжүүлсэн, захиран зарцуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ. |
| 46 | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр | 24.4 дүгээр зүйл.Эд мөрийн баримт хураан авах<br>5.Зарим онцлох эд зүйл, үнэт эдлэл, түүх, соёлын дурсгалт зүйлийг хураан авахад мэргэжилтнийг оролцуулж болно. |

**Гурав. Бусад эрх зүйн баримт бичгүүд**

| д/д | Үзэл баримтлал, хөгжлийн бодлого, чиглэл, хөтөлбөр, журам, дүрэм, заавар, жагсаалт | Баталсан шийдвэр, огноо |
|---|---|---|
| 1 | Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал | Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолын хавсралт |

| | | |
|---|---|---|
| 2 | Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал | Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралт |
| 3 | "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого | Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 сарын 13 өдрийн 52 дугаар тогтоолын хавсралт |
| 4 | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт |
| 5 | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 сарын 28-ны өдрийн 24 дугаар тогтоолын хавсралт |
| 6 | Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт | Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт (Засгийн газрын 2010-04-28-ны өдрийн 103 дугаар тогтоолоор 290 - 593 дахь заалт нэмж,"зохиогч" гэснийг "бүтээлч" гэж өөрчилсөн, Засгийн газрын 2011-12-28-ны өдрийн 373 дугаар тогтоолоор 610-670, Засгийн газрын 2012-02-29-ний өдрийн 58 дугаар тогтоолоор 671, Засгийн газрын 2012-04-04-ний өдрийн 105 дугаар тогтоолоор 672-748, Засгийн газрын 2013-6-26-ны өдрийн 227 дугаар тогтоолоор 749-776, Засгийн газрын 2015-9-28-ний өдрийн 390 дугаар тогтоолоор 777, Засгийн газрын 2019 оны 360 дугаар тогтоолоор 778 дахь заалтыг тус тус нэмсэн) |
| 7 | Бэлэг, дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам | Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт |
| 8 | Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт | Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт |
| 9 | Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам | Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт |
| 10 | Гамшигийн үед нүүлгэн шилжүүлэх журам | Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт |
| 11 | Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журам | Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 133 дугаар тогтоолын хавсралт |
| 12 | Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, зарцуулах, тайлагнах журам | Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 141 дүгээр тогтоолын хавсралт |
| 13 | Шүүхийн шийдвэрээр төрийн өмчлөлд шилжүүлсэн, гаалийн байгууллагад хураагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг соёлын өвийн сан хөмрөгт шилжүүлэх журам | Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 14 дүгээр тогтоолын хавсралт |
| 14 | Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам | Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолын хавсралт |
| 15 | Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед нүүлгэн шилжүүлэх журам | Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 288 дугаар тогтоолын хавсралт |
| 16 | Соёлын өвийг хамгаалахад идэвх санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 343 дугаар тогтоолын хавсралт |
| 17 | Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 121 дүгээр тогтоолын хавсралт |

| | | |
|---|---|---|
| 18 | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт |
| 19 | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт |
| 20 | Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолын хавсралт |
| 21 | Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Дэд бүтцийн сайдын 2004 оны 5-р сарын 24-ний өдрийн 183/111 дугаар хамтарсан тушаалын хавсралт |
| 22 | Монгол улсын музейн сан хөмрөгийн дүрэм | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын<br>2005 оны 11 дугаар сарын 8-ны өдрийн 347 дугаар тушаалын хавсралт |
| 23 | Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын<br>2009 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 78 дугаар тушаалын хавсралт |
| 24 | Музейн сан хөмрөгийг бүртгэх баримтжуулах заавар | Боловсрол,соёл, шинжлэх ухааны сайдын<br>2012 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн<br>А/355 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт |
| 25 | Соёлын өвийн судалгаа хийх журам | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны А/141 дугаар тушаалын хавсралт |
| 26 | Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/335 тушаалын 1 дүгээр хавсралт |
| 27 | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2019 оны А/237/92 дугаар тушаалын хавсралт |
| 28 | Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалын хавсралт |
| 29 | Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журам | Гаалийн ерөнхий газрын даргын<br>2008 оны 10 дугаар 10-ны өдрийн 660 дугаар тушаалын хавсралт |
| 30 | Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горим хэрэгжүүлэх журам | Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/41 дугаар тушаалын 2 дугаар хавсралт |
| 31 | Гаалийн хяналтын бүсийн журам | Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/294 дүгээр тушаалын хавсралт |
| 32 | Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам | Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалын хавсралт |

**Хавсралт 2**

## МОНГОЛ УЛСАД БҮРТГЭГДСЭН СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН СУДАЛГАА
### (Сүүлийн 5 жилээр)

| д/д | Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг | Гэмт хэргийн ангилал | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | 2021 он | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 17.1.2. Хулгайлах | Хүнд | 6 | 20 | 7 | 8 | 2 | **43** |
| 2 | 18.5.3. Улсын хилээр бараа хууль бусаар нэвтрүүлэх | Хүнд | 1 | 5 | 7 | - | - | **13** |
| 3 | 25.1.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах | Хөнгөн | - | 2 | 3 | 1 | | **6** |
| 4 | 25.2.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах | Хөнгөн | - | 1 | | | 2 | **5** |
| 5 | 25.2.2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах | | - | | | | 2 | |
| 6 | 25.3.1. Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх | Хөнгөн | | | 2 | 1 | 1 | **4** |
| 7 | 25.4.1. Хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийх | Хөнгөн | | | 1 | 2 | 1 | **4** |

Дээрх хугацаанд улсын хэмжээнд иргэдийн орон байр, гэр сууцанд нэвтэрч мөнгөн аяга, мөнгөн бүс, мөнгөн цөгц, алт, мөнгөн зэмэг, бөгж, бугуйвч, үсний даруулга, тоноглой эмээл, хазаар, ташуур, төрөл бүрийн чулуун хөөрөг, соруул гэх мэт үнэт эдлэл хулгайлсан 548 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

**Хавсралт 3**

# "ХУЛГАЙЛАГДСАН, ЭСХУЛ ХУУЛЬ БУСААР ЭКСПОРТЛОГДСОН СОЁЛЫН ЭД ЗҮЙЛСИЙН ТУХАЙ" ЮНИДРУА-ГИЙН КОНВЕНЦИД НЭГДЭН ОРСОН, ГАРЫН ҮСЭГ ЗУРСАН УЛСУУДЫН МЭДЭЭЛЭЛ

UNIDROIT INTERNATIONAL INSTITUTE FOR THE UNIFICATION OF PRIVATE LAW
*INSTITUT INTERNATIONAL POUR L'UNIFICATION DU DROIT PRIVE*

## UNIDROIT CONVENTION ON STOLEN OR ILLEGALLY EXPORTED CULTURAL OBJECTS
## *CONVENTION D'UNIDROIT SUR LES BIENS CULTURELS VOLÉS OU ILLICITEMENT EXPORTÉS*

| | |
|---|---|
| **Adoption:** | Place / *Lieu*: Rome / Date: 24-06-1995 |
| **Entry into force / *Entrée en vigueur*:** | Yes / *Oui* * Date: 01-07-1998<br>Conditions: 5 ratifications (Art. 12) |
| **Contracting States / *États contractants*:** | 52 |
| **Depositary / *Dépositaire*:** | Italian Government / *Gouvernement italien* |

| STATE / *ETAT* | SIGNATURE | RATIFICATION / ACCESS. / *ADHES.* | ENTRY INTO FORCE / *ENTREE EN VIGUEUR* | DECLARATIONS |
|---|---|---|---|---|
| Afghanistan | – | 23-09-05 | 01-03-06 | Arts. 16, 17 |
| Algeria / *Algérie* | – | 09-04-15 | 01-10-15 | Arts. 16, 17 |
| Angola | – | 19-06-14 | 01-12-14 | Arts. 16, 17 |
| Argentina / *Argentine* | – | 03-08-01 | 01-02-02 | Arts. 16, 17 |
| Azerbaijan / *Azerbaïdjan* | – | 06-06-03 | 01-12-03 | Arts. 16, 17 |
| Benin / *Bénin* | – | 11-01-21 | 01-09-21 | Arts. 3(5), 16, 17 |
| Bolivia / *Bolivie* | 29-06-96 | 13-04-99 | 01-10-99 | Arts. 16, 17 |
| Bosnia-Herzegovina / *Bosnie-Herzégovine* | – | 08-05-17 | 01-11-17 | Arts. 16, 17 |
| Botswana | – | 28-08-17 | 01-02-18 | Arts. 16, 17 |
| Brazil / *Brésil* | – | 23-03-99 | 01-09-99 | Arts. 16, 17 |
| Burkina Faso | 24-06-95 | 02-10-18 | 01-04-19 | Arts. 16, 17 |
| Cambodia / *Cambodge* | 24-06-95 | 11-07-02 | 01-01-03 | Arts. 16, 17 |
| China / *Chine* | – | 07-05-97 | 01-07-98 | Arts. 3(5), 16, 17 |
| Colombia / *Colombie* | – | 14-06-12 | 01-12-12 | Arts. 16, 17 |
| Côte d'Ivoire | 24-06-95 | 23-12-20 | 01-07-21 | Arts. 16, 17 |
| Croatia / *Croatie* | 24-06-95 | 20-09-00 | 01-03-01 | Arts. 16, 17 |
| Cyprus / *Chypre* | – | 02-03-04 | 01-09-04 | Arts. 16, 17 |
| Denmark / *Danemark* | – | 01-01-11 | 01-07-11 | Art. 14, 16, 17 |
| Ecuador / *Equateur* | – | 26-11-97 | 01-07-98 | Arts. 3(5), 16, 17 |
| El Salvador | – | 16-07-99 | 01-01-00 | Arts. 16, 17 |
| Finland / *Finlande* | 01-12-95 | 14-06-99 | 01-12-99 | Arts. 13(3), 16, 17 |
| France | 24-06-95 | – | – | – |
| Gabon | – | 12-05-04 | 01-11-04 | – |
| Georgia / *Géorgie* | 27-06-95 | – | – | – |
| Ghana | – | 20-09-19 | 01-03-20 | Arts. 16, 17 |
| Greece / *Grèce* | – | 19-07-07 | 01-01-08 | Arts. 13(3), 16, 17 |
| Guinea / *Guinée* | 24-06-95 | – | – | – |
| Guatemala | – | 03-09-03 | 01-03-04 | Arts. 3(5), 16, 17 |
| Honduras | – | 27-08-13 | 01-02-14 | – |
| Hungary / *Hongrie* | 24-06-95 | 08-05-98 | 01-11-98 | Arts. 3(5), 16, 17 |
| Iran (Islamic Rep. of / *Rép. islamique d'*) | – | 22-06-05 | 01-12-05 | Arts. 16, 17 |
| Italy / *Italie* | 24-06-95 | 11-10-99 | 01-04-00 | Arts. 13(3), 16, 17 |
| Lao People's Democratic Republic / *Rép. Dém. Pop. Lao* | – | 18-05-17 | 01-11-17 | Arts. 16, 17 |
| Latvia / *Lettonie* | – | 08-02-19 | 01-08-19 | Art. 16 |
| Lithuania / *Lituanie* | 24-06-95 | 04-04-97 | 01-07-98 | Arts. 16, 17 |
| Madagascar | – | 06-12-21 | 01-06-22 | Arts. 16, 17 |
| Montenegro | – | 08-07-19 | 01-01-20 | Art. 16 |
| Myanmar | – | 20-06-18 | 01-12-18 | Arts. 3(5), 16, 17 |
| Netherlands / *Pays-Bas* | 28-06-96 | – | – | Arts. 3(5), 13(3), 17 |
| New Zealand / *Nouvelle-Zélande* | – | 16-11-06 | 01-05-07 | Arts. 16, 17 |
| Nigeria / *Nigéria* | – | 10-12-05 | 01-06-06 | – |
| North Macedonia / *Macédoine du nord* | – | 22-08-13 | 01-02-14 | Arts. 16, 17 |
| Norway / *Norvège* | – | 28-08-01 | 01-03-02 | Arts. 13(3), 14, 16, 17 |
| Pakistan | 27-06-96 | – | – | – |
| Panama | – | 26-06-09 | 01-12-09 | Arts 3(5), 16, 17 |
| Paraguay | 13-06-96 | 27-05-97 | 01-07-98 | Arts. 16, 17 |
| Peru / *Pérou* | 28-06-96 | 05-03-98 | 01-09-98 | Arts. 16, 17 |
| Portugal | 23-04-96 | 19-07-02 | 01-01-03 | Arts. 16, 17 |
| Romania / *Roumanie* | 27-06-96 | 21-01-98 | 01-07-98 | Arts. 16, 17 |
| Russian Fed. / *Féd. de Russie* | 29-06-96 | – | – | – |
| Senegal / *Sénégal* | 29-06-96 | – | – | – |
| Slovakia / *Slovaquie* | – | 16-06-03 | 01-12-03 | Arts. 16, 17 |
| Slovenia / *Slovénie* | – | 08-04-04 | 01-10-04 | Arts 16, 17 |
| South Africa / *Afrique du Sud* | – | 09-01-18 | 01-07-18 | Arts. 16, 17 |
| Spain / *Espagne* | – | 21-05-02 | 01-11-02 | Arts. 3(5),13(3), 16, 17 |
| Sweden / *Suède* | – | 28-06-11 | 01-12-11 | Arts. 13(3), 16, 17 |
| Switzerland / *Suisse* | 26-06-96 | – | – | – |
| Syrian Arab Republic / *République arabe syrienne* | – | 27-04-18 | 01-10-18 | Arts. 16, 17, D |
| Togo | – | 03-09-21 | 01-03-22 | Arts. 16, 17 |
| Tunisia / *Tunisie* | – | 02-03-17 | 01-09-17 | Arts. 16, 17 |
| Zambia / *Zambie* | 24-06-95 | – | – | – |

**Хавсралт 4**

## ХУЛГАЙЛАГДСАН, ЭСХҮЛ ХУУЛЬ БУСААР ЭКПОРТЛОГДСОН СОЁЛЫН ЭД ЗҮЙЛСИЙН ТУХАЙ ЮНИДРУА-ГИЙН КОНВЕНЦИЙН ХАВСРАЛТ БОЛОН МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ, БУСАД ЭРХ ЗҮЙН АКТУУДАД ТОДОРХОЙЛСОН СОЁЛЫН ЭД ЗҮЙЛ /СОЁЛЫН БИЕТ ӨВ/-ИЙН АНГИЛАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ

| № | *Конвенцийн хавсралтын заалтууд* | *Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл, заалт* | *Бусад хууль, эрх зүйн актуудад тусгагдсан байдал* |
|---|---|---|---|
| | | I | II |
| 1 | (а) Амьтан, ургамал, ашигт малтмал, анатомийн болон палеонтологийн сонирхол татсан объектийн ховор цуглуулга болон сорьц; | 6.1.1.ховор эрдэс;<br>6.1.2.эрдэнийн чулууны ховор олдвор;<br>6.1.3.солир;<br>6.1.4.ховор болон ховордсон ургамлын хатаамал цуглуулга, амьтны чихмэл;<br>6.1.5.эртний ургамал, амьтны олдвор; | - амьтан, ургамал эрдэс судлал, анатоми, археологи, палеонтологийн цуглуулга ба цуглуулгын зүйлс,<br>- эрдэс, үнэт чулуу, сөнөсөн амьтан, ургамал, бичил биетний чулуужсан олдвор,<br>- эртний амьтны болон ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор,<br>- геологи, палеонтологи, хөрс, эрдэс судлал, ерөнхий биологи, ургамал, амьтан судлал, хүн судлал, ертөнцийн зүйн цуглуулга,<br>- геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, солир<br>- байгалийн түүхийг тодорхойлогч бодит материалууд. |
| 2 | (б) Түүх, түүний дотор шинжлэх ухаан, технологийн түүх, цэргийн болон нийгмийн түүх, үндэсний удирдагчид, сэтгэгчид, эрдэмтэд, уран бүтээлчидийн амьдрал болон үндэсний ач холбогдол бүхий үйл явдалтай холбоотой өмч; | 5.1.10.түүхэн үйл явдал болсон дурсгалт газр*ын холбогдох эд зүйл байж болно.* | - түүхийн болон шашны холбогдолтой эд өлгийн зүйл,<br>- монголын эрт, эдүгээгийн түүх, төр, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн түүх, хөгжлийг илтгэх бодит зүйл,<br>- ард түмний эрх чөлөөний хөдөлгөөн, цэрэг арми, улсын баатар, ахмад дайчдын амьдрал, түүхэн үйл явдал, шашны түүх, эртний судлалын цуглуулга, эд зүйлс,<br>- утга зохиол, урлагын зүтгэлтнүүдийн түүх, намтар, гарын үсэг, гэрээслэл,<br>- нэрт уран бүтээлчдийн дурсгалтай холбоотой зүйлс. |
| 3 | (в) Археологийн малтлага (өрдийн болон нууц аль аль нь орно) юмуу археологийн нээлтүүдээс гарсан бүтээгдэхүүнүүд; | 6.1.6.археологийн олдвор;<br>30.Олдвор;<br>52.1.эх олдвор;<br>52.3.1.палеонтологи, археологийн олдвор | - археологийн олдвор,<br>- археологийн ба палентологийн олдвор. |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | (г) Урлагийн юмуу түүхэн хөшөө дурсгал юмуу хуваагдсан археологийн газруудын элементүүд; | 5.1.1.эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар;<br>5.1.2.эртний хүний оршин суужбайсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга;<br>5.1.3.чулуун зэвсгийн олдворт газар;<br>5.1.4.хадны зураг, бичээс;<br>5.1.5.булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;<br>5.1.6.эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал;<br>5.1.7.хөшөө дурсгал;<br>5.1.8.эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;<br>5.1.9.тахилгат газар;<br>5.1.11.бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд*ын хэсэг байж болно.* | - Түүхэн дурсгалт барилга,<br>- архитектурын дурсгал<br>- археологи, палеонтологийн дурсгал |
| 5 | (д) Бичээс, зоос, сийлбэр зэрэг зуугаас илүү жилийн настай эртний эдлэлүүд; | 6.1.17.бусад түүх, соёлын дурсгалт зүйл. | - зоос судлалын чиглэлийн цуглуулга,<br>- эртний бичээс, зоос, тамга тэмдэг,<br>- хадны зураг, бичээс, им, тамга,<br>- эртний эдлэл. |
| 6 | (е) Угсаатны зүйн нөлөө бүхий биетүүд; | 6.1.7.угсаатны хувцас, чимэглэл;<br>6.1.8.уламжлалт аж ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөрийн багаж зэвсэг;<br>6.1.9.угсаатан, ястны уламжлалт хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйл;<br>6.1.10.уламжлалт тоглоом, наадгай;<br>6.1.11.уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл;<br>6.1.15.уламжлалт монгол эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэрэглэгдэхүүн, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл; | - угсаатан зүйн хэрэглэгдэхүүн,<br>- угсаатны зүйн цуглуулга. |
| 7 | (ё) Урлагийн нөлөө бүхий өмч:<br><br>- (i) зураг, уран зураг болон ямар ч дэмжих зүйлийн оролцоогүй аливаа материал дээр зөвхөн гараар | 6.1.14.дүрслэх урлагийн бүх төрлийн бүтээл, холбогдох эд өлгийн зүйл; | - урлагийн бүтээл<br>- урлагийн үнэт бүтээл,<br>- урлаг, дурсгалын зүйл,<br>- гар урлал, урлагийн бүх төрлийн болон соёл судлалын бүтээл,<br>- дүрслэл ба гоёл чимэглэл, ардын гар урлал, үндэсний |

| | | | |
|---|---|---|---|
| | бүтээгдсэн урлагийн бүтээл (гараар чимэглэсэн бүтээгдэхүүний загвар болон үйлдвэрлэсэн зүйлс орохгүй)<br>- (ii) аливаа материал дээр бүтээгдсэн уран барилга болон уран баримлын эх бүтээл;<br>- (iii) сийлбэр, хэвлэл болон хэвлэлийн барын эх ;<br>- (v) аливаа материал дээрх урлагийн цуглуулга болон эвлүүлэгийн эх; | | уран барилгын түүх, хөгжлийг харуулсан материал. |
| 8 | (ж) Ганцаарчилсан буюу цуглуулгын ховор гар бичмэл болон эртний хэвлэл, хуучин номнууд, бичиг баримт болон тусгай нөлөө бүхий нийтлэлүүд (түүх, урлаг, шинжлэх ухаан, утга зохиолын гэх мэт); | 6.1.12. бичгийн дурсгалт зүйл; | - гар бичмэл, ном судар,<br>- ном, судар, шащдир, угийн бичиг,<br>- судар болон хуучин ном, гар бичмэл,<br>- эртний ном судар, бичгийн дурсгал,<br>- уран зохиолын бүтээлүүд, зохиолын эх ноорог.<br>- ном ба дууны нот |
| 9 | (з) Ганцаарчилсан буюу цуглуулгын шуудан, улсын орлогын тамга болон түүнтэй ижил марк; | 6.1.17.бусад түүх, соёлын дурсгалт зүйл. | - |
| 10 | (и) Архив, түүний дотор дуу, гэрэл зургийн болон кино урлагийн архив; | 6.1.13. дүрс, дуу авианы баримт; | - цирк, театр, чуулга, дуу хөгжим, кино дүрс бичлэг, гэрэл зураг. |
| 11 | (и) Зуугаас илүү жилийн настай тавилга болон хуучны хөгжмийн зэмсэгийн зүйлс. | 6.1.16. гэр, сууц, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл; | - |

**Жич:** Хүснэгтийн I дэх баганад Конвенцийн хавсралтын ангилалд шууд хамаарах болон хамааруулж болох Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн зүйл, заалтуудыг; II дахь баганад Эрүүгийн хууль, Соёлын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Номын сангийн тухай хууль, "Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт", "Монгол улсын музейн сан хөмрөгийн дүрэм", "Түүх соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхэд лиценз олгох журам" зэрэгт тусгагдсан соёлын өв /түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлс, музейн үзмэрүүд/-ийн талаарх заалт, нэр томьёог багтаасан болно.